МАНАЙ СОНИНЫ III УЛИРЛЫН ЗАХИАЛГА ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

MMINFO.

18 дахь жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,089,359.. ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.06.17. Баасан. №123 (4493) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

**УЛС ТӨР**

СОНГУУЛИЙН ШОУ ХИЙЖ, ЭДИЙН ЗАСГИЙГ СҮЙРЭЛД ХҮРГЭЖ БАЙНА

IV нүүрт

**ДЭЛХИЙ**

УРЛАГИЙН БҮТЭЭЛЭЭС ҮҮДЭЖ АЛБАН ТУШААЛААСАА ОГЦРОВ

VI нүүрт

**АМЖИЛТЫН ЭЗЭН**



# Д.ОТГОНБААТАР: ПАУЭРЛИФТИНГ БОЛ ЭР ХҮНИЙ ШАНДАС ШАЛГАСАН СПОРТ ДОО

Дэлгэрэнгүйг V нүүрнээс

Дугаарын 60 мөр

## Дугуй түрээсэлмээр байна

Н.ПУНЦАГБОЛД

Улаанбаатар хотдоо дугуйн замтай болох санаачилгыг улстөрч нэртэй хүн болгон гаргасан нь үнэн. Ядаж л ярьдаг. Яг үнэн хэрэг дээрээ өнөөдрийг болтол хэрэгжүүлсэн нь цөөхөн байна. Өнгөрсөн дөрвөн жилд энд тэнд бага сага дугуйн зам шийдлээ. Яахав оргүйгээс гэдэг шиг эхлэлийг нь ч болов тавиад өгчихлөө. Угаасаа дугуйн битгий хэл машин замгүй байсан Улаанбаатар хот харин ч өнгө орчихсон. Эвдэрхий замаа засаад овоо болгочихлоо. Эхнээсээ дугуйн замтай болж байна. Яваандаа энэ мэтээр асуудлаа шийдээд явбал дугуйн зам нэмэгдэх нь тодорхой. Энэ сонгуулийн дараа гарч ирж, төр барих хүмүүс хэн ч байлаа гэсэн дугуйн зам, бүтээн байгуулалтын асуудалд анхаарлаа хандуулах байх. Ингэж өөдрөгөөр төсөөлж байна.

Үргэлжлэл нь III нүүрт

# ХЭН ЮУ ХЭЛЭВ

Б.ТОГТОХ

*УИХ-ын болон орон нутгийн сонгууль эхэлсэн энэ үед улстөрч бүхэн л улс орныхоо талаар санаа зовсон, эсвэл шийдэл эрсэн мэдэгдэл хийж буй. Гэвч бид энэ удаад "Хэн юу хэлэв" буландаа УИХ-д нэр дэвшч буй эрхмүүдийг онцлохыг хүссэнгүй. Харин сонгууль угтсан шоу ирэх онуудад эдийн засагт ямар хүндрэл авчрах талаар тооцоо судалгаатай ярьсан эдийн засагч болон нэр дэвшихийг горилоогүй улстөрчийн яриа, мөн нийгмийн анхаарал татсан зарим асуудлыг онцлохыг хүслээ.*

## Р.Амаржаргал: Эдийн засаг ирэх жилүүдэд нэлээд хүндрэхээр байна

-УИХ-ын гишүүн Р.Амаржаргал 2012 онд бүрдсэн парламентаас УИХ-д нэр дэвшилгүй үлдсэн цөөхөн хэдэн улстөрчдийн нэг. Тэгвэл эрхэм гишүүн өөрийн фэйсбүүк хуудсандаа Монгол Улсын эдийн засгийн ирээдүйн төлвийн талаар байр сууриа илэрхийлжээ.

Үргэлжлэл нь III нүүрт

**Улаанбаатарт: ӨНӨӨДӨР**




БАРИМТ ФАКТ

# 26.9 ИХ НАЯДААР ҮНЭЛЭГДЭХ ГАЗРЫН НАЙМААГ ИЛЧЛЭВ

Э.ТУУЛ

*Хотын дарга Э.Бат-Үүл, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Д.Баттулга тэргүүтэй албаныхан өчигдөр нийслэлийн өмнөх удирдлагуудтай холбоотой газрын хууль бус наймааны талаар баримттай мэдээлэл хийлээ. Хурлын эхэнд Хотын дарга Э.Бат-Үүл нийслэлийн өмнөх удирдлагууд буюу М.Энхболд, Т.Билэгт, Ц.Батбаяр, Г.Мөнхбаяр нар Хотын даргаар ажиллах хугацаандаа 26.9 их наяд төгрөгийн газар олголт хийсэн ч хотын төсөвт сохор зоос ч оруулсангүй болохыг мэдэгдлээ. Тэд өмнө нь энэ асуудлыг хөндөж байсан. Бүр тоо баримттай нь дэлгэж байсан билээ. Энэ баримтыг Дэлхийн банкны 2013-2015 оны хооронд хийсэн судалгааны 83 дугаар хуудсан дахь "Хотын өмнөх удирдлагуудын газар олголтоос алдсан орлогын тооцоолол" гэх хүснэгтэд дурьдсан байна. Ингээд мэдээллийг дэлгэрүүлэн хүргэе.*

## Алдагдсан эрх мэдлээ олж авах гэж улайран тэмцэж байна

Хотын дарга Э.Бат-Үүл энэхүү мэдээллийг хийх болсон шалтгаанаа "Өнөөдөр миний хэвлэлд хандах болсон шалтгаан нь Улаанбаатар хотын өмнөх удирдлагуудын хууль бус газар олголтын баримтууд руу олон нийтийн анхаарлыг хандуулахаас аргагүйд хүрч байгаа явдал юм.

Үргэлжлэл нь II нүүрт

**МОНГОЛ АРДЫН НАМ ХАНДИВЫН ДАНСАА НЭЭЛЭЭ**

"ХААН БАНК"
5115028001 тоот данс

**Иргэн та хандив өргөхдөө**

*Сонгуулийн тухайн хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу:*
*50.1.1 Иргэн гурван сая төгрөг хүртэл /регистерийн дугаар/*
*50.1.2 Хуулийн этгээд арван таван сая төгрөг хүртэл //регистерийн дугаар/*

**Сонгуулийн тухай хуулийн 40.3 д:**

... "Сонгуулийн зардлын мөнгөн хөрөнгийг банкинд нээлгэсэн, сонгуулийн зардлын дансанд энэ хуульд заасан журмын дагуу төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулна" гэсэн.,

заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн зардлын дансыг нээсэн тул намын гишүүд, дэмжигчид, дэмжигч байгууллага, иргэд та бүхнийг хандив өргөхийг хүсье.




**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 1954.00 | 1967.00 | ФУНТ | 2728.00 | 2809.00 |
| ЕВРО | 2184.00 | 2236.00 | РУБЛЬ | 28.10 | 31.90 |
| ИЕН | 18.50 | 19.05 | ЮАНЬ | 295.30 | 298.80 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 1956.00 | 1968.00 | ФУНТ | 2737.00 | 2812.00 |
| ЕВРО | 2180.00 | 2238.00 | РУБЛЬ | 28.85 | 31.63 |
| ИЕН | 18.55 | 19.11 | ЮАНЬ | 295.30 | 299.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

УЛС ТӨР

БАРИМТ ФАКТ

# 26.9 ИХ НАЯДААР ҮНЭЛЭГДЭХ ГАЗРЫН НАЙМААГ ИЛЧЛЭВ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Яагаад энэ цаг үеийг сонгов гэхээр нэгдүгээрт, сүүлийн өдрүүдэд над руу болон миний гэр бүл рүү маш их дайрч давшлах, гүтгэж гүжирдэх давалгааг газраар хөлжсөн хөрөнгөлөг бүлэглэл өрнүүлж байна. Өнгөрсөн 26 жилийн хугацаанд би хувь хүнийхээ хувьд ардчиллыг зүхэгчдийн гүтгэлэг, дайралтын бай болсоор ирсэн. Намайг хүний ёсноос гадуур яаж гүтгэн гүжирдэж, доромжилсоор өнөөдрийг хүргэснийг сонгогчид сайн мэднэ. Журмын нөхрөө алсан гэх гүтгэлгийг олон жилийн турш миний нэр дээр, миний хамтран зүтгэгчид дээр дэгдээж дэвэргэж ирсэн. Сонгуулийн жил эхэлмэгц энэ улигт гүтгэлэгээ давтаж, улмаар гэр бүл, үр хүүхдийг минь элдэв гүжирдлэгтээ ашиглаж байна.

Хоёрдугаарт, энэ бүх гүтгэлэг дахин сэргэж байгаа, улам увайгүй төрхтэй болж, нийслэлийн газраас зоргоор авч, жирийн оршин суугчдын эрх ашгийг хохироон өндөр өндөр байшин барьж асан цөөн бүлэг хөрөнгөлөг хүмүүс урьдын нөлөөлөл, явцуу эрх ашгаа сэргээн тогтоохын төлөө үгсэн хуйвалдаж, санхүүжүүлж, дайралтыг гардан зохион байгуулж байгаа нь улам бүр тодорч байгаад иргэдийн анхаарлыг хандуулах гэсэн юм. Гүтгэгчид, харлуулагчид иргэдийг төөрөгдүүлэхдээ гарамгай. Тэд юуг ч харлуулж, гутааж, дайсан болгож чаддаг. Тийм болохоор улаанбаатарчуудад урагшлахаас гадна ухрах ч боломж бодитоор байна. Олигархиудын мөнгөний өмнө сөгдөх, төөрөлдөх, дагаж давтах сонгогчид цөөн бус. Тийм болохоор нийслэлчүүд маань хэчнээн хүсэхгүй байгаа ч ухралт ялчих боломж байсаар байгаа юм. Хөрөнгөлөг цөөнх газрыг хууль журмын дагуу бус хуйвалдааны замаар олж авдаг байсан. Тэд мөнгөөр урхидан хүссэн газраа байшин босгож, өөрсдөө болж байвал иргэд яаж хохирох хамаагүй хэмээн сэтгэдэг байсан. Ардчилсан нам, жирийн иргэддээ хэвийн амьдрах эрх, түүнийгээ шаардах эрх чөлөөг нь олгоод зогсохгүй, хууль журамтай сайхан хотыг бүтээн босгохын үлгэр жишээг харууллаа. Чухам үүнд л хөрөнгөлөг цөөнх, олигархиуд хорсож аргаа барахдаа гүжрийн үгээр, хар хорын сэтгэлээр бархирч байна. Бид хууль журмаа мөрдсөнөөс өөр ямар ч гэм хийгээгүй” хэмээн тайлбарласан юм. Мөн үүний зэрэгцээ НИТХ-д НАН-аас нэр дэвшиж буй 45 хүн, иргэд сонгогчдоо ч сонор сэрэмжтэй, болгоомжтой байхыг сануулсан юм.






**Дэлхийн банкнаас гаргасан “Монгол Улс:** Улаанбаатар хотын газрын харилцаа ба менежмент” тайланд тусгагдсан Хотын өмнөх удирдлагуудын газар олголтоос алдсан орлогын тооцоолол хүснэгт

## Нийслэлийн 52 жилийн төсвийг салхинд хийсгэсэн хүмүүс ичих хэрэгтэй

2015 онд Дэлхийн банкнаас гаргасан “Монгол улс: Улаанбаатар хотын газрын харилцаа ба менежмент” гэсэн тайланд нэлээд ноцтой баримтууд бүртгэгджээ. Энэ тайланг Дэлхийн банкны Нийгэм, хот, хөдөө, сэргээн хөгжих асуудал эрхэлсэн газраас Улаанбаатар хотын захиргаатай хамтран 2013-2015 оны хооронд хийсэн судалгаанд тулгуурласан байна. Энэ тайлангийн 83 дугаар хуудсанд хотын өмнөх удирдлагуудын газар олголтоос алдсан орлогын тооцоолол гэсэн хүснэгт байх юм. Энэ хүснэгтийг харахаар 26 их наяд 976 тэрбум 42 сая төгрөгийн газрыг хотын өмнөх удирдлагууд олгожээ. Дэлхийн банкны судалгаагаар тогтоогдсон үнийн дүнг хамгийн багаар тооцсон бөгөөд 2012 он хүртэлх хугацаанд Хотын даргаар ажиллаж байсан хүмүүс шударга ажиллаж байсан бол хотын төсөвт ийм хэмжээний мөнгө орох байжээ. М.Энхболд, Т.Билэгт, Ц.Батбаяр, Г.Мөнхбаяр гэсэн дөрвөн хүн хотын даргын алба хашч байхдаа эрх мэдлээ ашиглан олгосон газрын үнийг төсөвт төвлөрүүлсэн бол 26 мянган сургууль, цэцэрлэгийн цогцолбор барьж, эсвэл Улаанбаатар хотод одоо эхлүүлээд байгаа Гэр хорооллын дахин төлөвлөлт, барилгажилтын ажлыг бүрэн дуусгаж болох байсан. Гэтэл тэд бидэнд ямар ч мөнгө байгаагүй, хэрвээ мөнгө байсан бол өнөөдрийн энэ ажлуудыг хийчих л байсан хэмээн гоншигонож, эдүгээ алдагдсан эрх мэдлийг ямар ч хамаагүй аргаар булаан авах гэсэн бохир оролдлогуудыг хийж эхлээд байгаа аж. Тэд хууль бусаар газар олгохдоо сургууль, цэцэрлэгийн талбай, нийтийн эзэмшлийн зам талбай, бүр СӨХ-ны газрыг ч үлдээлгүй, зарсан байсан. Хууль бусаар олгосон гэх газарт Төв шуудангийн өмнөх явган зорчигчийн зам, Төв талбайн урд хэсэг буюу одоо машины зогсоол болсон хэсэг, орос III сургууль болон VI сургуулийн хөлбөмбөгийн талбай, Улсын III төв эмнэлгийн хашаа, зогсоол, Хүүхдийн ордны баруун хойд булангийн явган хүний зам, ногоон байгууламжууд ч багтжээ. Ийм л хүмүүс өнөөдөр эрх мэдлийн төлөө улайран тэмцэж, замдаа таарсан хэнийг ч бяц гишгэхээр зүтгэж байхын оронд нийслэлийнхээ газар нутгаас зарж идсэндээ ичих хэрэгтэй.

## Тэмцээд, цэгцлээд байгаа хүмүүсээ багаар нь сонгож үз

Ийм л байдлыг эдүгээгийн Хотын удирдлагууд засч, залруулж, ажлаа авсныхаа дараа 200 гаруй газрын зөвшөөрлийг хүчингүй болгожээ. Харин нэгэнт хууль бусаар олгогдсон барилга, байшин барьсан газрыг тэр чигт нь үлдээсэн гэсэн юм. Түүнчлэн барилга бариагүй, дамлан зарахаар нөөцөлсөн гэх газруудаас дуудлага худалдааны анхны үнийг төлбөрийн хугацаат график гарган нэхэмжилж байгаа аж. 2012-2016 оны хугацаанд нийт 68 тэрбум 493 сая төгрөгийг дуудлага худалдааны анхны үнэ гэж тооцож, төсөвт төвлөрүүлсэн бол 2016-2019 онд 10 тэрбум 506 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тооцоолжээ. Хүснэгтэд байгаа нь хууль хяналтынхны шалгаж тогтоогоод байгаа л газрын хэмжээ. Нийт газар олголтыг нэгбүрчлэн шалгах нь маш их цаг хугацаа, баримт мэдээлэл шаардаж байгаа аж. Хууль бусаар олгогдсон газарт нэгэнт баригдчихсан байшин барилгыг шинэ удирдлага өршөөн хэлтрүүлсэн гэдгийг энд цохон тэмдэглэмээр байна. Харин барилга байгууламж баригдаагүй, дамлан худалдах зорилгоор нөөцөлсөн газруудаас дуудлага худалдааны анхны үнийг төлбөрийн хугацаат график гарган нэхэмжлэх ажил дуусаагүй. Гэтэл газар зарсан гэх энэ баримтыг МАН-ынхан өөрсдөө хэвлэлээр гаргаж, цагдаад нэгийгээ өгснөөр тодорхой болсон байдаг аж. Хотын дарга асан Г.Мөнхбаяр, Т.Билэгт, газрын албаны дарга байсан Ц.Сандуй тэдний гар хөл Э.Ариунгэрэл, Д.Дашцэцэг зэрэг хүмүүсийн 240 удаагийн газрын наймааны хэргийн талаар Сү.Батболдын фракцийнхан цагдаад мэдээлснээр шалгаж эхэлсэн байгаа юм. Тэд сайндаа ч биш өөрийн фракцийн Д.Цогтбаатарыг Барилга, Хот байгуулалтын сайдаар томилуулахын тулд өрсөлдөгч фракциас сайдад нэр дэвшсэн Ц.Сандуйгаа унагах гэж үүнийг хийсэн байдаг. Тэдний мэдээллийн дагуу Төрийн данс руу орох ёстой байсан 280 тэрбум төгрөг хаачсаныг тогтоохоор ажиллаж байгаа гэж цагдаагийнхан мэдээлсэн байна билээ. Хэрвээ дээрх газруудыг хууль ёсоор дуудлага худалдаагаар зарсан бол 26.9 их наядаас ч их мөнгө хотын төсөвт орох байв. Дуудлага худалдаа хэзээ ч анхны үнэ дээрээ тогтдоггүй шүү дээ. Хотын дарга Э.Бат-Үүл “МАН-ын үеэс ялгаатай нь Ардчилсан нам нийслэлийн удирдлагыг авмагцаа газрын харилцаа, хот төлөвлөлт, барилгажилтад гарч буй хууль бус үйлдэл, зөрчлийг таслан зогсоож, газар өмчлөх, ашиглахыг хууль журмын дагуу болгох алхмуудыг хийсэн. Миний санаачлагаар өнгөрсөн жил газар олгох журамд маш том өөрчлөлт оруулсан нь Хотын удирдлагын зүгээс хууль бусаар газар олговол шууд огцордог байх заалт юм. Бид иргэдээс асуухгүйгээр, тэдний оролцоогүйгээр газар олгохын эсрэг зогсдог. Энэ зарчимдаа тууштай байна. Өмнөх дарга нарын хууль, журам зөрчиж олгосон газруудаас бид ядаж дуудлага худалдааны анхны үнийг өг гэсэн шаардлага тавьснаар 2012-2016 оны хооронд нийт 68 тэрбум 493 сая төгрөгийг дуудлага худалдааны анхны үнэ хэмээн авч төсөвт оруулжээ. Газрын харилцааг хууль журмын дагуу болгоход л хэсэгхэн газраас ийм их мөнгө хотын төсөв буюу нийтийн хармаанд оржээ. Цаашид 2016-2019 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 10 тэрбум 506 сая төгрөг төсөвт орох болно” хэмээсэн юм. Дашрамд дурьдахад, Улаанбаатар гэдэг их айлыг 500 тэрбумын жилийн төсөвтэй гээд бодохоор “газрын мафи” гэж нэрлэгдсэн дээрх нөхдүүд нийслэлийн 53 жилийн төсвийн хөрөнгийг залгичихсан байгаа юм. Энэ мөнгийг “газрын мафи”-ийнхан залгичихалгүй нийслэлийн төсөвт оруулсан бол өнөөдөр амлаад байгаа “Аз жаргалтай хот”-оо аль хэдийнэ бүтээчих байж. Намынхаа ханаж цаддаггүй хүмүүсийг жаахан хазаарласан бол өмнөх нийслэл мөнгөтэй байж. Ийм их мөнгийг хэдүүлхнээ хувааж идэж байхаар байнга мөрийн хөтөлбөртөө амладаг цэцэрлэг, сургуулиа барихгүй яасан юм бэ. Ийм л булай, булхайтай нөхдүүд эдүгээ албан тушаалын төлөө амиа ч хайрлахгүй тэмцэж байна. Хийх ёстой цаг үедээ хэнэггүй царайлчихаад одоо хийнэ гэж юу байх вэ. Хийнэ гэж хэн ч сайхан амлаж чадна. Харин хийж байгаа, бүтээж байгаа хүмүүс л бидэнд чухал. Тиймээс Бат-Үүлээ багаар нь дахиулахыг уриалж байна.

| Газар ашиглалтын төрөл | Хэмжээ (м.кв) | м.кв-ын зах зээлийн үнэ | Зах зээлийн нийт тооцоолсон өртөг | Нийт алдагдсан орлого |
|---|---|---|---|---|
| Худалдаа, үйлчилгээ | 89’135’877 | 286’772 | 25’561’673’719’044 | 25’538’561’056’044 |
| Өрхийн хэрэгцээний | 13’363’215 | 107’570 | 1’437’481’037’550 | 1’437’481’037’550 |
| **НИЙТ ДҮН** | | | **26’976’042’093’594** | |

Хотын хуучин удирдлагын үед хууль бус олгогдсон нь бүрэн тогтоогдсон газруудын хэмжээ

| Нийслэлийн Засаг дарга асан хүмүүс | Захирамж гарсан огноо | Нийт олгогдсон талбай | Дуудлага худалдааны анхны үнэ | Нийт үнийн дүн |
|---|---|---|---|---|
| М.Энхболд | 2003.05.02-11.12<br>2004.01.14-12.10<br>2005.02.15-12.29 | 56’627’000 мкв<br>9’514’000 мкв<br>16’150’300 мкв | 13200₮ | 117 тэрбум 727 сая төгрөг |
| Ц.Батбаяр | 2006.02.15-11.17<br>2007.01.31-12.01 | 2’385’000 мкв<br>1’399’000 мкв | | 133 тэрбум 293,6 сая төгрөг |
| Т.Билэгт | 2008.04.17-11.02 | 3’339’000 мкв | | |
| Г.Мөнхбаяр | 2009-01.28-12.14 | 5’360’000 мкв | | |
| **ДҮН** | | **94774300 мкв буюу 9477,4 га** | | **1,2 их наяд** |

*/Жич: Энэ бол хууль хяналтынхны шалгаж тогтоогоод байгаа л газрын хэмжээ/*

Нэр дурдагдсан Хотын дөрвөн даргаас хамгийн сүүлд алба хашч байсан Г.Мөнхбаярын хууль бусаар олгосон газруудын талаархи мэдээллийг задалбал:

| Захирамж гаргасан огноо | Талбайн хэмжээ | Дуудлага худалдааны анхны үнэ | Олгосон газрын нийт үнэ |
|---|---|---|---|
| 2010.01.18-07.16 | 3132000 мкв | 13 200₮ | 308 тэрбум 906,4 сая төгрөг |
| 2010.08.20-12.28 | 7838000 мкв | | |
| 2012.01.20-06.22 | 1890000 мкв | | |
| 2011.02.08-06.21 | 5352000 мкв | | |
| **НИЙТ ДҮН** | | 2340 га | |

ACEM-11

## АСЕМ-ийн гишүүн орнууд хүнсний асуудлаар чуулах нь

Б.САРНАЙ

АСЕМ-ын бэлтгэл ажлын албанаас өчигдөр “Ази-Европын Хүнсний аюулгүй байдлын зөвлөлдөх уулзалт” сэдвийн хүрээнд “Монцамэ” агентлагийн АСЕМ-ын мэдээллийн төвд хэвлэлийн бага хурал хийлээ. Хуралд ХХААЯ-ны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Биндэръяа, ГХЯ-ны Европ, Америкийн газрын захирал М.Цэнгэг оролцсон юм.

ХХААЯ-ны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Биндэръяа хэлэхдээ “АСЕМ-ын дагалдах хурлуудын нэг болох Ази-Европын Хүнсний аюулгүй байдлын зөвлөлдөх уулзалт энэ сарын 20-21-нд Улаанбаатарт болно. Энэхүү уулзалтад АСЕМ-ын гишүүн 17 орны хүнс хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, Монгол дахь Элчин сайдын яамд, консулын газрууд, олон улсын байгууллагын төлөөллүүд оролцоно. Уулзалт хүнсний үйлдвэрлэл, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, хоол тэжээл гэсэн сэдвийн хүрээнд зохиогдоно” гэв. Тодруулбал, Ази, Европын бүс нутгийн хүнсний хангамжийн асуудал, Хөдөө аж ахуйн гаралтай органик хүнсний үйлдвэрлэл, баталгаажуулалтын асуудал, Генийн өөрчлөлттэй хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл цаашдын чиг хандлага, Мал амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүний хорио цээр, хил дамнасан малын халдварт өвчин, Хүнсний нэмэлт бүтээгдэхүүний зохистой хэрэглээ анхаарах асуудлууд зэрэг илтгэлүүд тавигдах аж. Ази, Европын бүс нутгийн хүнсний хангамж, хүнсний бүтээгдэхүүний худалдаа, тээвэр, логистик, уур амьсгалын өөрчлөлт, хүнсний аюулгүй байдал, хүнсний хангамжид үзүүлж буй нөлөө зэрэг асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэх гэнэ. Манай улс дээд төвшний уулзалтыг зохион байгуулснаараа олон улс, бүс нутгийн тавцан дахь байр суурийг бэхжүүлэх, баримталж буй бодлого, байр сууриа сурталчлан таниулахад ихээхэн ач холбогдолтой юм.

ШАР МЭДЭЭ

## Ерөнхий сайд хууль зөрчсөн үү

Х.НАРАНЦАЦРАЛ

Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийг сонгуулийн хууль зөрчсөн тухай УИХ-ын сонгуулийн 69 дүгээр тойрогт Иргэний Зориг ногоон намаас нэр дэвшигч С.Батбаатар А.Баярхүү нар өчигдөр “Монгол ньюс” мэдээллийн төвд мэдэгдэл хийлээ. Тодруулбал, Сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1-д “Ээлжит сонгуулийн жил эхэлсэнээс хойш санал хурааж дуустал аливаа этгээд сонгогчдын саналыг татах, үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж заасан байдаг. Тэгвэл УИХ-ын 52 дугаар тойрогт нэр дэвшч буй Ерөнхий сайд Ч.Сайханбилэг нь Сонгуулийн хуулийн 70.1.8-д заасны дагуу “хишиг, хувьцаа тараах, санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг хориглоно...” гэх мэт заалтыг албан тушаалын давуу байдлыг ашиглан зөрчсөн байна гэлээ. Хурлын үеэр ИЗНН-аас нэр дэвшигч С.Батбаатар “Сонгуулийн сурталчилгаа эхэлсэн энэ өдрүүдэд хишиг хувьцаа тараана гэж иргэдийн тархийг угааж байна. Нэг хүнд 300 мянга гэхээр 900 тэрбум төгрөг Монголын Засгийн газарт байхгүй. Энэ бол цэвэр сонгуулийн шоу.Тиймээс би өмгөөлөгчөөрөө дамжуулан нэхэмжлэлээ шүүхэд хүргүүлнэ. Одоогийн байдлаар Сүхбаатар дүүргийн цагдаагийн дөрөвдүгээр хэсэгт гомдол гаргасан” байгаа гэв.

mminfo.mn Шударга, Шуурхай, Онцгой мэдээлэл

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Б.ӨНӨРТОГТОХ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

## ҮЗЭЛ БОДОЛ






# ХЭН ЮУ ХЭЛЭВ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Тэрбээр, “Дэлхийн зах зээл дээр түүхий эдийн идэвхжил суларснаас үүдэн Монгол Улсын гадаад худалдааны эргэлт огцом буурч, төлбөрийн тэнцэл болон төсвийн алдагдлыг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна. Монгол Улсын хувьд урсгал дансны тэнцлийн тогтворгүй байдал нь ирээдүйд гадаад валютын нөөц болон гадаад өр төлбөрөө төлөхөд ихээхэн хүндрэлтэй байдлыг үүсгэхээр байна. Мөн дотоод эрэлт буурсантай уялдан эдийн засгийн бодит салбар зогсонги байдалтай байна. Чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж байгаа нь банк, санхүүгийн салбарт эмзэг байдлыг үүсгээд байгаа. Иим нөхцөлд Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд иргэд маань сонгох, сонгогдох эрхээ эдэлж ард түмний хүсэл зорилгыг илэрхийлэгч байх учиртай УИХ-аа эмхтгэнэ. Төрөл бүрийн мэргэжил, нийгмийн давхаргын төлөөлөл УИХ орж ирэх буруу биш ээ. Гагцхүү сонгуульд дэвшч байгаа нам, эвсэл, бие даагчдад тулгамдсан асуудлыг ойлгож шийдвэрлэх арга замыг олоход нь тус дэм болох үүрэгтэй институц бүтэц болон улс төрийн бодлого агуулсан тогтолцоо маш сул байгаа нь дээрх эдийн засгийн хүндрэлийг улам даамжруулахаар байна. Иймд төрийн институцийн тогтолцоог сайжруулах үүднээс улстөржилгүйгээр мэргэжлийн Засгийн газар байгуулах шаардлага тулгарч байна” хэмээн бичсэн байна. Эрхэм гишүүн өнгөрсөн дөрвөн жилд олон ч удаа мэргэжлийн Засгийн газартаа байхыг хүсч буйгаа илэрхийлж байсан юм.

> ...Чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж байгаа нь банк, санхүүгийн салбарт эмзэг байдлыг үүсгээд байгаа. Иим нөхцөлд Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд иргэд маань сонгох, сонгогдох эрхээ эдэлж ард түмний хүсэл зорилгыг илэрхийлэгч байх учиртай УИХ-аа эмхтгэнэ...

### Ж.Дэлгэрсайхан: Хувьцааг мөнгөжүүлсэн нь буруу шийдвэр

-“Эрдэнэс Тавантолгой” компанийн 1072 ширхэг хувьцааны 30 хувийг Засгийн газар худалдаж авахаар болсон билээ. Өнгөрөгч долоо хоногт арилжааны банкууд ачааллаа дийлэхээ больж, хувьцаагаа зарах гэсэн иргэдийн очер дараалал ихсээд байгаа юм. Тэгвэл энэхүү шийдвэрийг эдийн засгийн үүднээс нь Санхүү эдийн засгийн дээд сургуулийн багш, Эдийн засагч Ж.Дэлгэрсайхан дүгнэснийг “news.mn” сайт нийтэлжээ. Ж.Дэлгэрсайхан “Эдийн засгийн огт боломжгүй үед гаргаж буй буруу шийдвэр. Зөвхөн сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гэж харж байна. Хэрэгжүүлж буй цаг хугацааг хар л даа. Сонгуулийн сурталчилгаа эхлэх үетэй давхацлаа. Тараах үеийг нь харвал сонгуулийн санал өгөх хугацаатай давхцаж байна. Монгол Улсын Засгийн газарт ийм эдийн засгийн боломж байхгүй. Ямар нэг байдлаар санхүүжүүллээ ч гэсэн эргээд эдийн засагт, “Эрдэнэс Тавантолгой” компанид хохиролтой шийдвэр. Иргэдийн орлогын төвшин бага, амьжиргаа дор байгааг ашигласан явдал. Өөрөөр хэлбэл, Засгийн газар эрх мэдлээ буруу ашиглалаа гэсэн үг. Иргэдийн хувьд өмнө нь цэнхэр, ягаан тасалбарын гашуун туршлага бий. Мөн Засгийн газрын удаа дараагийн амлалтуудад хуууртаж, хүлээж цөхөрсөн байдалтай. Тиймээс иргэдийг буруутгах аргагүй. Тэгээд ч Тавантолгойн үр ашиг хэзээ гарах нь эргэлзээтэй байдалд орсон. Үүн дээр нэмээд дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ, Монгол Улсын өмнөд зах зээл рүү гаргаж буй нүүрсний хэмжээтэй холбоотой эргэлзээтэй асуудлууд бий. Тийм болохоор хувьцаагаа мөнгө болгоё гэсэн иргэдийг буруутгах арга байхгүй” хэмээн байр сууриа илэрхийлсэн байна. Эдийн засагчдын дийлэнх хувь нь Засгийн газрын гаргасан энэхүү шийдвэрийг дэмжихгүй гэдгээ илэрхийлсэн билээ.

### Л.Нинжбат: Хуульчдын чадварыг шалгасан сонгууль болох нь

-УИХ-аар шинэчлэн баталсан хууль олон талаар шинэлэг, мөн нэр дэвшч буй хууччуулд бус шинүүдэд тун хатуухан хууль болж гарсан. Тэгвэл хуулийн төслийн талаар “gogo.mn” сайтын сэтгүүлч Хуульч Л.Нинжбаттай ярилцсаныг уншигч таньд тоймлон хүргэе. Л.Нинжбат хуулийн төслийн шинэлэг болон давуу тал, мөн анхаарах ёстой зүйл заалтын талаар ярихдаа “Сонгуулийн тухай хуулийн нэг гол онцлог нь маш олон хязгаарлалт, хоригтой. Нэн ялангуяа сонгуулийн сурталчилгааны зохицуулалтууд нь зөвхөн энэ хуульд заасан арга, хэлбэрээр хийгдэхийг л зөвшөөрсөн. Өөрөөр хэлбэл хуульд зааснаас өөр арга, хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа хийсэн бол нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах хүртэл зохицуулалттай. Намын удирдлагаас бусад этгээдүүд заавал үнэмлэхжинэ. Энд заасан этгээдүүдээс өөр үнэмлэхгүй хүмүүс сонгуулийн сурталчилгаа явуулбал тэр нь хуулийн зөрчил болох учиртай. Иймд нэр дэвшигчид олны танил хүмүүсийг өөрийн албан ёсны сурталчилгаанд ашиглахдаа нэлээд бодолтой байх ёстой болов уу. Арга хэрэгслийн хувьд хэвлэмэл материал тараах, радио, телевиз, интернэтээр хийх сурталчилгаа, ухуулах байр, уулзалт, хурал цуглаан хийх, зурагт самбар байрлуулах, намын далбаа ашиглах гэх мэт цөөн төрлийн сурталчилгааг зөвшөөрсөн. Өөрөөр сурталчилгаа хийж болохгүй. Хамгийн энгийн жишээ гэхэд нэр дэвшигчийн сурталчилгааны штаб нь ухуулагч, шадар туслагч нараа ижил футболк, саравчтай малгайгаар хувцаслалаа гэхэд хувцсан дээрээ нэр дэвшигчийн нэр, уриа бичихийг хориглосон. Улс төрийн тавцанд нэгэнт олонд танигдаад “брэнд” болчихсон хүмүүсийн хувьд өөрсдийгөө дахин сурталчлах шаардлага бараг үгүй. Гэтэл шинэ залуу улстөрчдийн хувьд ийм хязгаарлалттай хуулийн хүрээнд сонгогдож гарах магадлал багатай хууль болсон байна гэдгийг судлаачид хэлж байна. Миний харж байгаагаар энэ сонгуулиар хуульчдын “тулаан” цөөнгүй болох байх. Хуульчид өчүүхэн алдаа гаргаж, нэр дэвшигчийг хууль зөрчихөд хүргэвэл нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах эрсдэлтэй. Өчнөөн олон зуун сая төгрөг сонгуульдаа зарцуулчихаад мэдлэггүй, эсвэл хайнга нэгэн хуульчаасаа болоод нэрээ татуулчихвал харамсалтай биз. Ер нь сонгуулийн хуулийн зөрчилтэй холбоотой зөрчил, маргаан их гарах төлөвтэй байна. Энэ сонгууль хуульчдын мэдлэгийг, шүүхийн шударга байдлыг шалгана” хэмээжээ.

### Р.Барсболд: Манайд шинжлэх ухаан хэрэггүй бололтой

-Баянзүрх дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Шинжлэх ухааны академийн Палеонтологи, геологийн хүрээлэнгийн байрыг тус дүүргийн прокурорын газарт шилжүүлэх тухай 270 дугаар тогтоолыг Монгол Улсын Засгийн Газраас гаргасан билээ. Тэгвэл энэ шийдвэрийн талаар Шинжлэх ухааны академийн Палеонтологи, геологийн хүрээлэнгийн палеонтологич, геологич Р.Барсболд байр сууриа илэрхийлжээ. Тэрбээр, “Манай хүрээлэнгийн байр зориулалтынх биш. Ер нь манай улсад зориулалтын байр байдаг юм уу. Хэрвээ дүүргийн прокурорын газарт шилжүүлэх юм бол 40-өөд эрдэмтэн, судлаачид багтах шингэх газаргүй болно. Мөн үлэг гүрвэлийн чулуужсан яснаас өгсүүлээд нүдэнд харагдахгүй шахуу чулуужсан бактерийн ор мөр хүртэл хадгалагддаг. Нүүлгэн шилжүүлэх боломжгүй олон олдворууд бий. Манай олдворыг дэлхий хүлээн авч байна. Тухайлбал, Япон улсын Нагоя хотод манай үлэг гүрвэлийн үзвэрийг хоёр сарын хугацаанд нийтэд дэлгэн үзүүлсэн. Энэ хугацаанд үзвэрийг 990 мянган хүн үзсэн байдаг. Энэ бол иргэдээ соён гэгээрүүлж буй том хөрөнгө оруулалт. Гэтэл дотоодод шинжлэх ухаан хэрэггүй гэж үздэг байхад гадны улсад манай орныг хүн ам багатай ч өргөн уудам нутагтай, нийгмийн хөгжлөөр тааруу ч хүн төрөлхтний танин мэдэхүйн шинжлэх ухааны салбарт асар их үүрэгтэй хэмээн үнэлж байх жишээтэй” гэв.


# ХОНГ КОНГ РУУ НИСЛЭГ ҮЙЛДЭЭД 5 ЖИЛ БОЛЖЭЭ

Үндэсний Агаарын Тээвэрлэгч МИАТ ТӨХК өнөөдрөөс яг 5 жилийн өмнө Хонг Конг хот руу тогтмол шууд нислэг анх үйлдэж эхэлсэн билээ. МИАТ ТӨХК энэ хугацаанд 833 нислэг үйлдэж 208,749 зорчигч, 826 тонн ачаа тээвэрлэжээ. Өнөөдөр МИАТ компани Хонг Конг хот руу долоо хоногт 5 удаа буюу даваа, мягмар, пүрэв, баасан, ням гарагуудад нислэг үйлдэж байна.

Дашрамд дурдахад зорчигчдын тээшний журмыг шинэчлэн ширхэгийн системд шилжээд байна. Ингэснээр зорчигчод энгийн ангилалаар аялсан тохиолдолд 23кг НЭГ ширхэг, бизнес ангилалаар аялсан тохиолдолд 32кг НЭГ ширхэг тээш үнэгүй тээвэрлэх боломжтой боллоо.





Дугаарын 60 мөр

# Дугуй түрээсэлмээр байна

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Тийм болохоор манай бизнесмэнүүд дугуй түрээсийн үйлчилгээнд анхаарлаа хандуулаад, хөгжүүлэх гээд үзвэл яасан юм бэ. Манайхаас гадаад явж, туршлага судлах дуртай. Тийм ч оронд очиж, тэгж ч туршлага судаллаа гээд л төрийн албан хаагчид бөөн бөөнөөрөө тив алгасан бизнес ангилалаар нисдэг нь худлаа биш. Тэгвэл дугуйн зам болоод дугуй түрээсийн үйлчилгээг манай өмнөд хөршийнхөн жинхэнэ утгаар нь хөгжүүлчихэж. Бээжин, Хөххот зэрэг томоохон хотуудад дугуй түрээсийн үйлчилгээ ид цэцэглэн хөгжиж байгаа юм билээ. Тэгэхдээ иргэдэд бүр амар байх шийдлийг хүртэл олчихсон. Дугуй түрээсийн газар гээд байшин барилга байхгүй байна. Зүгээр л гудамжид, дугуйн зогсоолтой, тэндээ түгжээд тавьчихсан байдаг. Түрээслэх хүн нь карттай байдаг аж. Тэгээд дугуйн зогсоол дээр нь очоод, картаа уншуулж мөнгөө төлөөд, цоож нь тайлагдаад дугуйгаа унаад явчихна. Хамгийн гоё нь тийм дугуй түрээслүүлдэг зогсоол хотын хаа сайгүй байдаг юм билээ. Нэг газраас дугуй түрээсэлж авсан хүн заавал буцааж аваачиж өгөх гэж цаг заваа гарздах шаардлагагүй. Харин очих гэж байгаа газрынхаа ойролцоо байгаа өөр нэг зогсоолд тавиад, картаа уншуулаад л гүйцээ. Хэдэн минут, цагийн хугацаанд хэрэглэснээсээ шалтгаалаад картнаас нь мөнгө нь хасагдаад явчихна. Дээрээс нь түрээсийн дугуй нь нэг загварын, ижил өнгөтэй. Бусад дугуйнуудаас эрс ялгарахаар. Хаана ч явж байсан энэ түрээсийн дугуй байна гэдэг нь мэдэгдэхээр, танигдахаар юм билээ. Манайх энэ үйлчилгээг яагаад хөгжүүлж болохгүй гэж. Гэхдээ Монголд яаж шийдвэр зүгээр вэ гэдэг аргыг нь бас олох хэрэгтэй байх. Манайхан их хотын соёл, орчинд арай л суралцаагүй байгаа хүмүүс шүү дээ. Тийм болохоор дугуй түрээслэнэ гэхээр тэр чигт нь унаад явчихаж мэдэх л хүмүүс. Тийм болохоор картандаа тэдэн төгрөгтэй, барьцаа маягаар байрлуулдаг байх хэрэгтэй ч байж болох юм. Ямар ч байсан нэг шийдэл байгаа. Бид өнөө цагт машины утаанаас үүдэлтэй агаарын бохирдолттой тэмцэж байгаа. Дээрээс нь замын түгжрэлтэй ч бас тэмцэл хийж байна шүү дээ. Энэ тэмцэлд оруулах нэг том хувь нэмэр бол дугуйн зам. Цаашлаад дугуй түрээсийн үйлчилгээ. Хүн бүр шууд дугуй аваад унах боломж хомс. Тиймээс зайлшгүй дугуй түрээсийн үйлчилгээ хэрэгтэй байгаа юм. Бид одооноос л бага багаар хөгжүүлж эхэлж байж, 5, 10 жилийн дараа огт өөр хэмжээнд очно шүү дээ.

# УЛС ТӨР

ӨӨР ӨНЦӨГ




# СОНГУУЛИЙН ШОУ ХИЙЖ,
## ЭДИЙН ЗАСГИЙГ СҮЙРЭЛД ХҮРГЭЖ БАЙНА

Эдийн засгийн ухааны доктор
Х.БААТАР

УИХ, аймаг нийслэлийн сонгуулийн сурталчилгаа эхэлсэн энэ үед эрх барьж буй АН-ын Засгийн газар болон нийслэлийн удирдлагуудын зүгээс иргэдийн саналыг татах зорилгоор хууль зөрчсөн олон үйлдэл гаргаж, Монгол Улсын эдийн засгийг дампуурлын ирмэгт хүргэж байна. Тухайлбал, сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхлэхийн өмнөхөн АН-ынхан сонгогчдод гэнэт хайр зарлаж, “Сайн оюутан”, “Сайн хашаа”,“Сайн хувьцаа” зэрэг арга хэмжээг ар араас нь зарлаж эхлэв. Гэтэл АН-ынхан засгийн эрх барьсан дөрвөн жилийнхээ хугацаанд энэ мэт ажлыг огт хийгээгүйгээр барахгүй эдийн засгийг элгээр нь хэвтүүлсэн нь гарцаагүй үнэн билээ. Гэсэн атлаа сонгууль болохын өмнөхөн нийгмийн давхарга бүрт чиглэсэн “Сайн” тодотголтой хөтөлбөрүүдийг зарлаж байгаа нь цэвэр сонгуулийн шоу юм. Иргэдийг энэ мэт урт насгүй хөтөлбөртөдийхнөөрхуурчбашир аргаар саналыг нь худалдаж авах гэсэн ажиллагаанаас өөр юу ч биш гэдгийг сонгогчдод сануулах нь зүйтэй болов уу. Үгүй ядахдаа л АН-ынхан дөрвөн жилийн турш энэ мэт иргэддээ чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсээр ирсэн бол өнөөдөр ард түмэн орлогогүй, нийгэм тэр чигээрээ ядууралд автахгүй байх байлаа. Цаашлаад гаднаас авсан “Чингис”, ”Самурай” зэрэг их хэмжээний бондын мөнгийг үр ашиггүй зүйлд баруун солгойгүй цацаж, Монгол Улсын гадаад өрийг 23 тэрбум ам.долларт хүргэчихээд байгаа нь ёстой л “Хэний гавьяа вэ”. Цаашлаад улсын төсвийн алдагдал энэ оны тавдугаар сарын байдлаар 600 гаруй тэрбумд хүрч, төрийн албан хаагчдын цалинг зээлээр тавихад хүрээд байна. Эрх баригчдын бодлогын алдаа Монгол Улсыг ингэж арга ядсан, өрийг өрөөр дардаг байдалд хүргэв. Эцсийн дүнд нь ард түмэн ядуурч, АН-ын цөөн хэдэн албан тушаалтанд л “Чингис”,“Самурай” бондын мөнгө үр ашгаа өгсөн хэмээн хэвлэлээр шуугиж байгаа нь оргүй зүйл биш гэдгийг хэн хүнгүй мэдэж л байгаа. Тийм ч учраас холбогдох байгууллага нь бондын мөнгөний зарцуулалтыг шалгаж, үнэн мөнийг тогтоох цаг нь өнөөдөр ч байж болох.

Өнөөдөр АН-ынхан иргэд сонгогчдын саналыг татахын тулд эдийн засгаараа тоглож, засгийн эрхийг ямар ч хамаагүй аргаар авахын төлөө улайрч байгаа нь харамсалтай. АН засгийн эрх барих сүүлийн нэг сарынхаа хугацаанд ард иргэдэд эзэмшүүлсэн “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 1072 хувьцааны 30 хувийг худалдан авах шийдвэрийг Засгийн газраараа гаргуулав. Энэ нь хувьцаа гэх үгээр халхавч хийн хууль зөрчиж буй нэг хэлбэр гэдгийг эдийн засагчид хэлж байгаа. Тухайлбал, хувьцаагаа зарах эрхтэй хүмүүсийг зөвхөн 18-аас дээш насныхан гэсэн нь сонгуулийн насныханд чиглэсэн, шоу төдий арга хэмжээ гэдгийг бэлхнээ илтгээд байгаа юм. Түүнчлэн “Эрдэнэс-Тавантолгой”-нхувьцаагхудалдах, худалдан авах ажиллагаа нь Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн болон Компанийн тухай хуулиар зохицуулагдах ёстой. Тухайлбал, “Засгийн газар 2012 оны 181 дүгээр тогтоолын 3 дугаар заалтын дагуу хоёр дахь зах зээлийн арилжаа эхлэх хүртэлх хугацаанд “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцааг саналын эрхгүй, аливаа хэлбэрээр захиран зарцуулахгүй байх нөхцөлтэйгөөр иргэдэд эзэмшүүлэхээр заасан байдаг. “Эрдэнэс Тавантолгой”-н хувьцаа нь өнөөг хүртэл Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгэгдээгүй, хувьцааны арилжаа эхлээгүй байгаа учир хувьцаа эзэмшигч иргэд хувьцаагаа арилжаалж, өвлүүлэх, барьцаалах боломжгүй байгаа” юм. Иймээс сонгуулийн насны иргэдийн хувьцааны 30 хувийг худалдан авах шийдвэрийг Засгийн газраас гаргаж байгаа нь хууль бус бөгөөд ердөө л иргэдийн саналыг авах гэсэн явуургүй арга юм. Цаашилбал, хувьцаа худалдаж авах Засгийн газрын шийдвэрийг 1072 хувьцаатай холбон үзэх хууль зүйн үндэсгүй бөгөөд хувьцаа худалдаж авах нэрээр сонгуулийн насны иргэдэд бэлэн мөнгө тарааж, улсын өрийг 300 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж байгааг энд дурдъя. АН-ынхан үнэхээр л иргэдийн хувьцааг амь оруулахыг хүссэн бол өнгөрсөн жилүүдэд, бүр тодруулбал засаг барьсан дөрвөн жилийнхээ хугацаанд хуулийн дагуу зохион байгуулж, 1.65 сая иргэнийг насаар ялгаварлалгүй хувьцааг нь худалдан авч болох л байв. Гэтэл тэд өөрсдөдөө тааруулан хууль “зохиож”, 18 наснаас дээш хүмүүсийн хувьцааг худалдан авна гэчихэв. Монголбанк Засгийн газрын байгууллага шиг ажиллаж, хүссэн үед нь зээл олгон хувьцаа нэрийн дор иргэдэд мөнгө тараах ажиллагааг зохион байгуулж эхэллээ.

> ...АН сонгуулийн санал авахын тулд Засгийн газрын өрийг нэмэгдүүлэн, банк санхүүгийни байгууллагыг ашиггүй ажиллахад хүргэж байна. Сонгуулийн үеэр авч хэрэгжүүлж байгаа 300 мянган төгрөг олгох болон зээлийн арга хэмжээнүүд нь улсын төсөв, эдийн засагт ихээхэн дарамт учруулж, Монгол Улсын эдийн засгийг сүйрлийн ирмэгт хүргээд байна...

Угтаа Хувьцаа худалдан авах тухай Засгийн газрын тогтоолд дотоодын бондын мөнгөөр уг арга хэмжээг санхүүжүүлнэ гэж байгаа боловч энэ сарын 13-наас хэрэгжүүлж байгаа учир бонд гаргах цаг хугацааны боломж байхгүй юм. Тийм ч учраас Монголбанкнаас зээл авч, санхүүжүүлж байгаа бололтой. Дээрээс нь энэ онд гадаадаас авсан 750 сая ам.долларын зээл ч Засгийн газарт байх учиртай. Энэ мэтээр хууль зөрчин хэрэгжүүлж байгаа хувьцаа худалдан авах ажиллагааны цаана эдийн засагт ямар сөрөг нөлөө үзүүлэхийг дор дурдъя. Тухайлбал, хамгийн наад захын жишээ 300 мянган төгрөгийг иргэдэд тарааснаар инфляц өснө. Үүнийг дагаад өргөн хэрэглээний бүхий л бараа бүтээгдэхүүний үнэ өсөх нь гарцаагүй. Энэ нь эргээд та, бидний амьдралд сөрөг нөлөө үзүүлнэ гэсэн үг. АН-ынхан ингэж эдийн засгийг улам уруу татав.

Харин цаана нь тэдний хүссэн үр дүн тийм ч амар гарахгүй нь ойлгомжтой. Өөрөөр хэлбэл, сонгогч иргэд Засгийн газраас өгсөн 300 мянгыг авч таарна. Харин 300 мянган төгрөгөөр саналаа худалдахгүй нь мэдээж. Тэд маргаашаа, ирээдүйгээ бодож сонголтоо хийнэ. Эдийн засгийг хямралаас гаргаж, ард түмний амьдралыг дээшлүүлж чадах намаас УИХ болон аймаг, нийслэлд нэр дэвшиж байгаа хүмүүст л саналаа өгч таарна. Шинээр гарах УИХ, Засгийн газар “Тавантолгой” төслийг богино хугацаанд, үр ашигтайгаар эдийн засгийн эргэлтэд оруулж, иргэдийн 1072 хувьцааг Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид бүртгүүлэн үнэ цэнэтэй болгож, иргэдэд ногдол ашиг авах, хувьцаагаа арилжаалах боломж бүрдүүлэх хэрэгтэй. Тавантолгой ашигтай ажиллах тусам хувьцааны бодит үнэ хэд дахин өсч, иргэдийн 1072 хувьцааг нэг сая төгрөг бус хэдэн сая болгож, бодит үнэ нь өсч таарна.

АН сонгуулийн санал авахын тулд Засгийн газрын өрийг нэмэгдүүлэн, банк санхүүгийни байгууллагыг ашиггүй ажиллахад хүргэж байна. Сонгуулийн үеэр авч хэрэгжүүлж байгаа 300 мянган төгрөг олгох болон зээлийн арга хэмжээнүүд нь улсын төсөв, эдийн засагт ихээхэн дарамт учруулж, Монгол Улсын эдийн засгийг сүйрлийн ирмэгт хүргээд байна. Монголын эдийн засгийн хямрал улам гүнзгийрч байгааг мэдэрсэн гадны оронд байнга ажиллаж, амьдардаг иргэд мөнгөө тухайн орон руугаа татаж байгаа мэдээлэлэл ч байна. Харин энэ мэдээлэл нь манай банк, санхүүгийн салбарт ч сөрөг нөлөө үзүүлэх нь ойлгомжтой.

## Зүүн хойд Азийн орнууд Монголд хуралдаж байна

Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх “Улаанбаатарын яриа хэлэлцээ” олон улсын III бага хурал өчигдөр Гадаад хэргийн яамны хурлын танхимд болж байна. Энэ жилийн олон улсын бага хурлыг Гадаад хэргийн яам, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Стратегийн судалгааны хүрээлэн хамтран зохион байгуулж байгаа юм. Хоёр өдөр үргэлжлэх энэхүү бага хуралд БНХАУ, ОХУ, БНАСАУ, БНСУ, Япон, АНУ, Герман, Энэтхэг, Их Британи, Австрали, Францын эрдэмтэн судлаачид, НҮБ-ын олон улсын Улаан загалмайн хороо, Фридрих эбертийн сан зэрэг олон улсын байгууллагын төлөөлөл зэрэг 150 гаруй төлөөлөгчид чуулжээ. Энэхүү олон улсын бага хурлаар хэлэлцэх асуудал жил бүр өргөжиж байгаа бөгөөд анх удаа БНСУ болон БНАСАУ-ын төлөөлөгчид ирж, улсын аюулгүй байдлын асуудлын талаар ярилцаж байгааг зохион байгуулагчдын зүгээс онцолж байлаа.

## Саналыг хуудсыг цагдаагийн хамгаалалттай хэвлэж эхэллээ

Сонгуулийн ерөнхий хорооноос нийт 595 төрлийн хоёр сая орчим саналын хуудсыг цагдаагийн байгууллагын хамгаалалт, тагнуулын асуудал эрхэлсэн байгууллагын хяналт дор хэвлүүлж байна. Энэ удаагийн сонгуулийн саналын хуудсыг “Мөнхийн үсэг” компанид хэвлүүлж байгаа юм. Мөн Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан загвар, захиалсан тоо, чанар, шаардлагын дагуу саналын хуудсыг хэвлэж байгаа эсэхэд ажлын хэсэг хяналт тавьж байгаа аж. Саналын хуудасны эх бэлтгэл, хэвлэх, боож баглах, хүлээлцэх явцад хэвлэх үйлдвэрийн ажилчдаас гадна Ажлын хэсгийн гишүүд, нам, эвсэл, төрийн бус байгууллагын ажиглагчид ажиглалт хийж байгаа аж.

## Ерөнхий сайд мэдэгдэл хийнэ

Монгол-Япон улс хооронд байгуулагдсан эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр энэ сарын 7-ноос хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн билээ. Тэгвэл энэ хүрээнд манай улсаас дадлагажигчажиллаххүчинилгээхээрболж,Хөдөлмөрийн сайд Г.Баярсайхан, УИХ-ын дарга З.Энхболд нар мэдэгдэл хийж байсан билээ. Уг асуудлаар Хөдөлмөрийн яаман дээр тусгай ажлын хэсэг байгуулагдан, Япон руу дадлагажигч ажиллах хүчнээр явах хүсэлтэй иргэдийг хэрхэн бүртгэх, хэлний бэлтгэлд хамруулах зэрэг асуудлуудыг бодлогын хүрээнд боловсруулж буй юм. Тэгвэл энэ асуудлаар өнөөдөр Ерөнхий сайд Ч.Сайханбилэг албан ёсоор мэдэгдэл хийхээр болсон байна.

АЙЛЧЛАЛ

# Мьянмар улсад шашны сургуульд залуусаа сургах бодолтой гэв

Б.ЭРХЭС

Монгол Улс, Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойн хүрээнд Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж энэ сарын 14-16-ны өдрүүдэд Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсад ажлын айлчлал хийж байгаа билээ. Тэгвэл Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж өчигдөр Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч Тин Чяу-тай албан ёсны хэлэлцээ хийлээ.



Хэлэлцээний үеэр Мьянмарын Ерөнхийлөгч Тин Чяу хэлэхдээ “Монгол Улс, Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойн хүрээнд манай улсад ажлын айлчлал хийхээр хүрэлцэн ирсэн Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж танд гүнээ талархал илэрхийлье. Таныг Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсад тавтай морилохыг хүсье” гэв. Харин Ерөнхийлөгч хэлсэн үгэндээ “Намайг болон миний дагалдан яваа зочид төлөөлөгчдийг халуун дотноор хүлээн авсанд талархаж байна. Хоёр улсын хоорондын дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойн хүрээнд айлчилж байгаадаа баяртай байна. Манай хоёр улсын хооронд харилцаа хамтын ажиллагаагаа сайжруулах салбар, нөөц боломж их бий. Сүүлийн жилүүдэд хоёр талын өндөр дээд хэмжээний айлчлалын давтамж нэмэгдэж байгааг дурьдахад таатай байна. Мьянмарын Ерөнхийлөгчөөс эхлээд төрийн албан төлөөлөгчид Монголд айлчлан ирсэн. Энэ харилцааны дүнд хоёр улсын ард иргэд маань харилцан туршлага суралцах, бие биенээ дэмжих эрмэлзэлтэй болж байгаа нь хамгаас сайшаалтай. Монголчууд 1990-ээд оноос ардчилалд шилжин зах зээлийн эдийн засгийг сонгосон. Аливаа өөрчлөлт шилжилтийг хийх тухай ярих, хэрэгжүүлэх хоёр тэс ондоо. Энэ хүнд бэрх замыг туулсан бид сурсан мэдсэн зүйлээ бусадтай хуваалцахыг хүсдэг. Бид Мьянмар Улсад өргөн бүрэлдэхүүнтэй хүрэлцэн ирээд байна. Өнөөдөр бид “Байгалийн баялаг ашиглалтын зүй зохистой менежмент 2” семинарт оролцоод ирлээ. Энэхүү семинарт байгалийн баялгаас орох ашиг орлогыг хэрхэн оновчтой зарцуулах, ашгийг ард иргэдэд эн тэнцүү хуваарилахын тулд сайн засаглалыг бүрдүүлэх нь чухал гэх мэт чухал сэдвийг хөндөж ярилцлаа. Мьянмарын Ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллах болсонд тань баяр хүргэе. Таны манлайллын дагуу Мьянмар улам бүр хөгжин цэцэглэж, улам нээлттэй улс орон болно гэдэгт итгэлтэй байна” хэмээжээ. Мьянмарын Ерөнхийлөгч Тин Чяу “Ардчиллын замыг сонгон амжилт бүтээлээр дүүрэн яваа Монголын ард түмнээр бахархдаг. Энэ чиглэлээр манай хоёр орон харилцан туршлага солилцож байгаад баяртай байна. Монгол Улс өөрийн хөрш орнууд, бүс нутаг, тив дэлхийн орнуудтай, НҮБ тэргүүтэй олон улсын байгууллагуудтай эвийн сайхан харилцаатай байдгийг бид сайшаадаг” хэмээв. Ерөнхийлөгч хариу хэлэхдээ “Манай хоёр орны ард иргэд шашин шүтлэг, түүх соёл, оюун санааны сэжмээр холбогддог. Энэ чиглэлээр хамтран ажиллаж, буддын шашны сургуульд сурах сонирхолтой залуусаа харилцан илгээн сургах боломж бий. Мөн Монгол Улс нь олон улсын энхийг сахиулах ажиллагаанд идэвхитэй оролцон олон улсын цэргийн хээрийн сургалт, дадлагыг зохион явуулдаг. Энэ арга хэмжээнд Мьянмарын зэвсэгт хүчний бие төлөөлөгчдийг оролцуулбал бид нээлттэй хүлээн авах болно.

Мөн манай хоёр орны хооронд эдийн засаг, боловсрол, аялал жуулчлал, иргэд хоорондын харилцаа болон бусад салбаруудад харилцааг өргөжүүлэх өргөн боломж байна. Удахгүй Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо АСЕМ-ын дээд түвшний уулзалт болно. Энэ арга хэмжээнд Мьянмар Улс идэвхитэй оролцоно гэдэгт найдаж байна. Та бүхний оролцоо бидний хувьд томоохон дэмжлэг болно” хэмээв. Албан ёсны хэлэлцээний дараа Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч Тин Чяу нар хоёр талын баримт бичигт гарын үсэг зурах ёслолд оролцлоо. Мөн энэ өдөр Мьянмарын Төрийн зөвлөх бөгөөд Гадаад хэргийн сайд Аунг Сан Сү Чийтэй уулзлаа.

## СПОРТ

АМЖИЛТЫН ЭЗЭН



# Д.ОТГОНБААТАР: ПАУЭРЛИФТИНГ БОЛ ЭР ХҮНИЙ ШАНДАС ШАЛГАСАН СПОРТ ДОО

Н.БАТЗАЯА

*Энэ сарын 7-12-нд Энэтхэг улсад болсон пауэрлифтингийн Азийн АШТ-д манай улсаас эх орноо төлөөлөн зургаан тамирчин оролцсоноос М-1 ангиллын +120 кг-д Д.Отгонбаяр алт, М-1 ангиллын -120 кг-д Ц.Үүрцайх, насанд хүрэгчдийн 83 кг-д Б.Гансүх, 93 кг-д М.Батбаяр нар мөнгө, 59 кг-д М.Батмөнх хүрэл медалиар энгэрээ мялаасан юм. Азийн аварга болсон Д.Отгонбаатартай ярилцлаа.*

**-Юуны өмнө Ази тивийн аварга болсонд баяр хүргэе. ¬Тэмцээнийхээ талаар сонирхуулахгүй юу?**

-Баярлалаа. Энэтхэг улсын Удапур хотод энэ сарын 7-12-нд Пауэрлифтингийн Азийн тивийн аварга шалгаруулах 32 дахь удаагийн тэмцээн боллоо. Энэ тэмцээнд манай Пауэрлифтингийн холбооны зургаан тамирчин оролцож, 120 кг жинд нэг алт, 59 кг жинд нэг хүрэл медаль, насанд хүрэгчдийн 83 кг, -120кг жинд мөнгөн медаль хүртсэн. Нийт нэг алт, нэг хүрэл, гурван хүрэл медалийн амжилт үзүүллээ. Азийн аваргад Монгол Улсаа төлөөлж явсан тамирчдын тав нь амжилттай оролцож, медальт байрт шалгарсан. Энэ бол маш том амжилт юм. Би хувьдаа манай пауэрлифтингийн тамирчид багаараа маш сайн, амжилттай оролцсон гэж бодож байгаа. Би 120 кг жинд алтан медаль хүртэж, Пауэрлифтингийн 32 дахь удаагийн Азийн аварга болсон. Азийн аварга болсондоо маш их баяртай байна. Пауэрлифтингийн азийн аварга болсон нь зөвхөн миний хичээл зүтгэлийн үр дүн биш. Энэ амжилтыг гаргахад Монголын Пауэрлифтингийн холбоо, манай клубын хамт олон маш их тусалж, дэмжсэн. Бүгдэд нь баярлалаа.

**-Анх удаагаа олон улсын тэмцээнд оролцсон. Өндөр амжилт гаргалаа шүү дээ?**

-Миний хувьд олон улсын чанартай тэмцээнд анх удаагаа оролцсон. Өмнө Улсын аварга шалгаруулах тэмцээнд л оролцдог байлаа. Анх удаа олон улсын тэмцээнд оролцож, амжилт гаргасан учраас баяртай байна. Олон улсын анхны тэмцээн байсан учраас их сандарч бас догдоллоо.

**-Өрсөлдөгчид хэр байсан бэ?**

-Өрсөлдөгчид их хүчтэй байсан. Бусад орны тамирчид бэлтгэл их сайтай юм билээ. Ялангуяа Казак, Иран, Тайван зэрэг орны тамирчид хүчтэй өрсөлдөгч байлаа. Учир нь пауэрлифтингийн спорт өөрөө их хүч шаарддаг. Тийм болохоор ч юм уу жүдо хөгжсөн орны тамирчид сайн байсан. Тэр дундаа Казак улсаас ирж оролцсон тамирчид их хүчтэй. Олон улсын чанартай анхны тэмцээн байсан учраас өрсөлдөгчдөө судлахын зэрэгцээ, туршлага их хуримтлуулсан.

**-Тухайн орны цаг уур, амьдрах хэв маягаас хамаарч улс орон бүрийн тамирчид нэг онцлог давуу талтай байдаг. Манай улсын тамирчид бусад орны тамирчидтай харьцуулахад юугаараа давуу талтай байв. Анзаарч харсан байх?**

> ...Аливаа тэмцээн уралдаанд хэн нэгний дэмжлэггүйгээр оролцох их хэцүү. Тухайн тамирчинд их хэцүү л дээ. Бэлтгэл сургуулилтаа хиймээр байдаг. Гэтэл явах зардлын мөнгө нь бодогдоод тайван ч байж чадахгүй. Монголд Пауэрлифтингийн спортыг тодорхой хэмжээнд дэмжиж, тусалдаг хүмүүс бий. Харин шинжилгээний төлбөр зэрэг зарим зүйлийг холбооноос даасан...

-Пауэрлифтингийн Азийн аварга шалгаруулах тэмцээнд оролцож байхдаа нэг зүйлийг анзаарч байлаа. Тэр нь юу гэхээр, манай орон яалт ч үгүй бөхийн орон юм байна гэж бодогдсон. Эрийн гурван наадамд нь хүртэл бөх ордог шүү дээ. Манай тамирчид үнэхээр бяртай, тэнхээтэй юм билээ. Бөхийн удамтай, бөхийн орны тамирчид учраас ийм бяр, тэнхээтэй байдаг болов уу гэж бодсон. Бусад орны тамирчдаас ялгагдах гол зүйл нь гэвэл тэр. Мөн тамирчдыг хат суухад тухайн үндэстний амьдралын хэв маяг, байгаль орчин, цаг уурын байдал ч гэсэн нөлөөлдөг. Манай орон жилийн дөрвөн улиралтай. Зун нь нэг их халаад, өвөл нь их хүйтэрдэг. Энэ нь ч гэсэн тамирчдыг бяр тэнхээтэй болоход тодорхой хэмжээгээр нөлөөлдөг болов уу гэж бодсон. Мөн аливаа амжилтад хүрэхэд тухайн тамирчны хичээл зүтгэл маш чухал. Мянга бяр тэнхээтэй, бөхийн удамтай байлаа ч гэсэн хүчээл зүтгэл гаргаж, бэлтгэл сургуулилтаа сайн хийхгүй бол явахгүй. Манай тамирчид бэлтгэл сайн байсан. Үнэхээр бяртай тэнхээтэй юм билээ. Тэр нь ч гэсэн гаргасан амжилтаас нь харагдах байх. Казак, Иран, Тайван улсын тамирчидтай эхний байруудын төлөө л өрсөлдлөө. Ер нь манай тамирчдын бусад орны тамирчдаас ялгагдах давуу тал нь гэвэл илүү бяртай л гэж хэлнэ.

**-Монголын Пауэр-лифтингийн спортын хөгжил олон улстай харьцуулахад аль төвшинд байна вэ. Анх удаа олон улсын тэмцээн оролцсон. Гадаадын тамирчдаас туршлага судалсан хүний хувьд харьцуулалт, дүгнэлт хийсэн байх?**

-Манай пауэрлифтингийн тамирчид маш өндөр амжилт гаргадаг болсон. Ер нь Ази тивдээ маш дээгүүр өрсөлддөг тамирчдын тоонд ордог. Одоо бол Иран, Казак Тайван зэрэг орны тамирчидтай эхний байрын төлөө өрсөлддөг болсон. Тэгэхээр тамирчдын гаргасан амжилтуудаас Монголын пауэрлифтингийн спортын хөгжил аль төвшинд байгааг харж болох байх. Тухайлбал, 2014 онд Москвад болсон Дэлхийн аварга шалгаруулах тэмцээний 140 кг жинд Спортын мастер, Баянзүрх дүүргийн Биеийн тамир спорт хорооны дарга Д.Анхбаяр аваргалсан. 2014 дэлхийн аваргын тэмцээнд нийт 18 орны 1800 гаруй тамирчид оролцож байсан. Д.Анхбаяр тэр тэмцээнээс нэг алт, хоёр мөнгөн медаль хүртэж, дэлхийн аварга болж байлаа. Мөн 2014 олон улсын хэмжээний мастер М.Батбаяр 100 кг жинд дэлхийн аварга болсон. М.Батбаяр Ази тивийн аварга шалгаруулах тэмцээний мөнгөн медальт, Улсын аварга шалгаруулах тэмцээний алт, мөнгө, хүрэл медальтай. Эндээс манай улсын пауэрлифтингийн спортын хөгжил аль төвшинд байгаа нь харагдах болов уу. Монгол Улсад пауэрлифтингийн спортын Азийн аваргууд байна. Бүр дэлхийн аваргууд ч байгааг харж болно. Пауэрлифтингийн спорт Монголд хөгжиж байна. Гэхдээ энэ спортыг залуучуудад илүү таниулах хэрэгтэй. Тэгэхийн тулд төрөөс тодорхой хэмжээгээр дэмжих ёстой. Сая болсон Азийн аварга шалгаруулах тэмцээнд ч гэсэн манай тамирчид амжилт үзүүллээ. Тухайлбал, Олон улсын хэмжээний мастер М.Батбаяр 93 кг жинд мөнгөн медаль, 83 кг жинд Б.Гансүх мөнгөн медаль хүртсэн. Пауэрлифтингийн тамирчид маш амжилттай байгаа.

**-Та аль клубт харьяалагддаг вэ. Бэлтгэл сургуулилтаа хаана хийдэг вэ. Сая бэлтгэл нэлээд сайн байсан бололтой?**

-Би Багануур дүүргийн Боловсрол цогцолборт багшилдаг. Биеийн тамирын багш мэргэжилтэй. Багануур дүүргийнхээ спорт хороо, “Уурхайчин” клуб, “Хөх дөрвөлжин” клубт бэлтгэл сургуулилтаа хийдэг. Улсын аварга шалгаруулах тэмцээнээс олон улсын тэмцээний эрх авдаг учраас маш сайн бэлдэж ордог. Бэлтгэлийг боломжоороо сайн хийсэн. Ер нь тэмцээн уралдаан дөхсөн үед өдөр болгон шахуу бэлтгэл хийнэ. Би аливаа спортын амжилт бэлтгэл сургуулилтаас их шалтгаалдаг гэж боддог. Мэдээж сайн хөдөлмөрлөвөл тэр хэмжээгээр сайн үр шим хүртэнэ шүү дээ. Тиймээс бэлтгэл чухал.

**-Багш мэргэжилтэй хүн пауэрлифтингийн спортоор хичээллэх болсон түүх сонин байна. Яагаад энэ спортыг сонгож хичээллэх болсон юм бэ?**

-Пауэрлифтингийн спорт Монголд хөгжиж эхлээд 10 гаруй жил болж байна. Би анх 2005 оны улсын аварга шалгаруулах тэмцээнийг үзэж байсан юм. Тэр тэмцээн хамгийн анхны улсын аварга шалгаруулах тэмцээн л дээ. 2005 оны улсын аварга шалгаруулах тэмцээнийг үзэж байхад пауэрлифтингийн спорт надад маш их таалагдсан. Ёстой л эр хүний шандас шалгасан спорт шиг санагдаж билээ. Одоо ч гэсэн тэр тэмцээн нүдэнд харагддаг. Тэгээд л пауэрлифтингийн спортоор хичээллэхээр шийдсэн. Биеийн тамирын багш мэргэжилтэй болохоор бэлтгэл сургуулилтаа хийхэд ч гэсэн дөхөм юм шиг санагдсан. 2006 оны улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцсон цагаасаа хойш пауэрлифтингийн спорттой амьдралаа холбосон доо.

**-Хүмүүс ихэвчлэн пауэр-лифтингийг бодибилдингийн спорттой андуурдаг. Энэ хоёр спорт хоорондоо ямар ялгаатай юм бэ. Энэ талаар тайлбарлаж өгөхгүй юу?**

-Тийм. Ихэнхи залуус пауэрлифтингийн спортыг бодибилдингийн спорттой андуураад байдаг. Энэ бол цэвэр хүчний спорт. Ер нь шахалт, суулт, таталт гэсэн гурван төрөлтэй. Төрлүүдийнхээ нийлбэрээр дүнгээ гаргадаг. Бодибилдингээс ялгарах онцлог нь гэвэл хүчээрээ өрсөлддөг л спорт юм. Ер нь манай улс бөхийн орон гэдэг утгаараа тамирчид маань хүч чадлаараа илүү санагддаг.

**-Пауэрлифтингийн спорт их өртөг өндөртэй юм шиг санагддаг. Хувцас хэрэглэлээс эхлээд л олддоггүй юм шиг байна лээ?**

-Нэг үеийг бодвол пауэрлифтингийн спорт хөгжсөн. Өмнө хувцас хэрэглэл олдохгүй байх тохиолдол гардаг байлаа. Одоо харьцангуй гайгүй болсон. Нэг их зориулалтын хувцас олдохгүй байна гээд байх зүйлгүй.

**-Пауэрлифтингийн Азийн аварга шалгаруулах 32 дахь удаагийн тэмцээнд оролцохдоо зардлаа өөрсдөө гаргав уу. Хэн нэгний оролцоо байв уу?**

-Аливаа тэмцээн уралдаанд хэн нэгний дэмжлэггүйгээр оролцох их хэцүү. Тухайн тамирчинд их хэцүү л дээ. Бэлтгэл сургуулилтаа хиймээр байдаг. Гэтэл явах зардлын мөнгө нь бодогдоод тайван ч байж чадахгүй. Монголд Пауэрлифтингийн спортыг тодорхой хэмжээнд дэмжиж, тусалдаг хүмүүс бий. Харин шинжилгээний төлбөр зэрэг зарим зүйлийг холбооноос даасан. Манай пауэрлифтингийн холбоо болон зарим байгууллагууд биднийг дэмждэг шүү.

**-Биеийн тамирын багш мэргэжилтэй, пауэрлифтин-гийн тамирчны хувьд хүүх-дүүддээ энэ спортын талаар зааж, сургаж байгаа байх?**

-Тийм ээ. Мэдээж энэ спортоор хичээллэдэг тамирчин хүн, багш хүний хувьд хүүхдүүдэд зааж, сургалгүй яах вэ. Пауэрлифтингийн спортыг сонирхдог хүүхдүүд бий. Манай Багануур дүүргийн хүүхдүүд энэ жилийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцсон. Энэ жилээс л эхэлж оролцож байгаа юм. Нэг шавь маань хүрэл медаль хүртсэн. Маш их баяртай байгаа.

**-Пауэрлифтингийн спор-тоор хэдэн настайгаасаа эхэлж хичээллэвэл зүгээр байдаг юм бэ?**

-Пауэрлифтингийн спор-тоор хүүхдүүд ч гэсэн хичээллэх боломжтой. Ер нь сонирхож байгаа хүүхдүүд байвал 16 настайгаасаа эхэлж хичээллэхэд тохиромжтой. Пауэрлифтингийн спортыг сонирхож хичээллэдэг хүүхдүүд бий.

**-Та мөрөөдлийнхөө талаар хуваалцахгүй юу. Амжилттай явж байгаа тамирчин хүний хувьд олон зүйлийг хүсч, мөрөөдөж байгаа болов уу?**

-Тэгэлгүй яах вэ. Олон зүйлийг хүсч мөрөөдөж, дотроо бодож төлөвлөж явдаг. Миний хамгийн эхний зорилго гэвэл Дэлхийн аваргад оролцохыг хүсдэг. Пауэрлифтингийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн 2018 онд манай улсад зохион байгуулагдах юм. Тэр тэмцээнд л оролцохыг хүсч байна. Мэдээж манай улсад болох учраас надад боломж бий. Зардал мөнгөнөөс эхлүүлээд их боломжтой. Өөрийн оронд болж байгаа учраас сэтгэл санааны хувьд ч сайхан байх болов уу. 2018 оны пауэрлифтингийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх авахын тулд эхлээд улсын аваргад маш сайн оролцох хэрэгтэй. Тэгэхээр надаас бүх зүйл шалтгаална. Тиймээс бэлтгэл сургуулилтаа сайн хийнэ гэж бодож байна. Амжилтаа ахиулж, дэлхийн аваргад оролцохыг л хүсч байна даа.

**-Монголд хөгжих боломж байна уу?**

-Манай улсад энэ спорт хөгжих бүрэн боломжтой. Яагаад гэвэл би түрүүнд ч хэлсэн. Монголын залуучууд их бяртай, хүчтэй. Пауэрлифтингийн спорт өөрөө хүчний спорт. Тиймээс манай монгол залуус хичээллэхэд их тохиромжтой. Ер нь бол одоо Ази, Дэлхийн төвшинд гараад ирсэн. Энэ спортоор хичээллэвэл монголчууд амжилт олох боломжтой гэдгийг манай тамирчид харуулж чадлаа. Залуучуудыг энэ спортоор хичээллээрэй гэж уриалмаар байна.

**-Та энэ спортоор хичээллээд 10 жил болсон гэсэн. Энэ хугацаанд маш их туршлага хуримтлуулсан байх. Пауэрлифтингийн спортоор хичээллэж байгаа залуу тамирчид хэр санагдаж байна вэ. Тэдэнд амжилт гаргах ирээдүй байна уу?**

-Манай залуус маш их ирээдүйтэй. Бэлтгэл сургуулилтаа маш сайн хийдэг. Өсөх ирээдүйтэй тамирчид их байна. Сая болсон Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд М.Батмөнх гэж залуу 59 кг жинд оролцлоо. Анх удаагийн тэмцээн гэхэд залуучуудын ангиллаас хүрэл медаль хүртсэн. Ер нь манай залуус өөрсдөө хичээж, бэлтгэл сургуулилтаа хийх юм бол амжилт гаргах боломжтой.

**-Пауэрлифтингийн спор-тыг хөгжүүлэхэд төрөөс хэр дэмжлэг үзүүлэх юм?**

-Ер нь пауэрлифтингийн спортыг төрөөс дэмжих хэрэгтэй. Манай тамирчид тодорхой хэмжээнд амжилт гаргаж, Ази, Дэлхийн аваргатай боллоо. Цаашид энэ спортыг хөгжүүлэхийн тулд төрийн оролцоо чухал.

**-Таньд баярлалаа. Спортын өндөр амжилт хүсье.**

# ДЭЛХИЙ

## Доналд Трамп: Ким Жон Унтай бургер иднэ

АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд Бүгд найрамдах намаас нэр дэвших нь тодорхой болоод буй үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан 70 настай Доналд Трамп дэлхийн хамгийн хаагдмал улсын удирдагчтай уулзах хүсэлтэй байгаа талаараа өмнө нь мэдэгдсэн байдаг. Тэгвэл Жоржиа мужид хийсэн уулзалтынхаа үеэр Трамп хэлсэн үгэндээ тайлбар хийсэн байна. Тэрбээр "Би Хойд Солонгос явахгүй. Харин Ким Жон Ун Америкт ирвэл би хүлээж авахад бэлэн байна" хэмээгээд, "Гэхдээ энэ тохиолдолд албан ёсны тусгай оройн зоог барихгүй. Хурлын зориулалттай ширээний ард хачиртай талх л идчихнэ" гэж тайлбарлажээ. Түүний хэлсэн үг өмнө нь олон нийтийн дунд томоохон дуулианы тарьж, үүнийг өөрт ашигтайгаар эргүүлэхийг хүссэн Ардчилсан намаас АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Хиллари Клинтон ч шүүмжилсэн мэдэгдлийг хийсэн удаатай. Харин Трамп "Цөмийн зэсвэг ашиглахгүй байхад Ким Жон Уныг ятгах боломж 10, 20 хувь байна. Ярилцахад ямар нэг асуудал байгаа юм уу. Хиллари хөөрхий сонирхогч" хэмээж, өрсөлдөгчөө доош нь хийгээд амжсан байна.

# УРЛАГИЙН БҮТЭЭЛЭЭС ҮҮДЭЖ АЛБАН ТУШААЛААСАА ОГЦРОВ



Б.ДАВААХҮҮ

Японы нийслэл Токио хотын захирагч 67 настай Ёичи Масузоэ албан тушаалаа урвуулан ашиглаж, улсын төсвийг шамшигдуулсан хэргийнхээ хариуцлагыг үүрч, албан тушаалаасаа огцрох өргөдлөө албан ёсоор гаргажээ. Улмаар түүний өргөдлийг Токио хотын зөвлөл хүлээн авснаар энэ сарын 21-ний өдөр үүрэгт ажлаа хүлээлгэн өгөхөөр болсон байна. Түүнчлэн төсвийн мөнгө шамшигдуулсан гэх Ёичи Масузоэд итгэл үзүүлэх эсэх талаарх санал хураалт ч болжээ. Хотын Ерөнхий зөвлөл болон Комэй нам өнгөрөгч лхагва гарагийн өглөө түүнд итгэл үзүүлэх асуудлаар хуралдаж, ихэнх нь эсрэг байр суурийг илэрхийлснээр Ёичи хотын даргын суудлаас огцрохоос өөр аргагүй болсон байна. Эдүгээг хүртэл хотын Ерөнхий зөвлөл захирагчдаа итгэл үзүүлэх эсэх асуудлаар хуралдаж байсан тохиолдол бараг үгүй ажээ. Тэрбээр Токио хотын захирагчаар сонгогдсоноосоо хойш хоёр жил дөрвөн сарын хугацаны дараа огцорч буй нь энэ юм. Ёичи Масузоэг төсвийн хөрөнгөөр гэр бүлийн аялал зохион байгуулж, урлагийн олон арван бүтээл худалдан авсан хэрэгт буруутгаад байгаа юм. Японы зарим хэвлэлд бичсэнээр 67 настай Ёичи Масузоэ 2013 онд гэр бүлийн аялалд 2000 гаруй ам.доллар, 2014 онд мөн дээрх зорилгоор 1200 ам.долларыг төсвийн хөрөнгөнөөс шамшигдуулсан байна. Мөн 2012-2013 оны хооронд 13.260 ам.долларыг урлагийн бүтээл худалдан авахад зарцуулсан байж болзошгүй гэж орон нутгийн сонинууд уламжилж байгаа юм. Японы "Санкэй" сонинд бичсэнээр Ёичи "улс төр болоод мөнгө"-ний дуулианд нэр холбогдон Токио хотын захирагчийн үүргийг гүйцэтгэх хугацаагаа дуусгалгүй суудлаасаа бууж буй хоёр дахь хүн болж байгаа аж. Хотын сонгуулийн Ерөнхий хорооноос мэдээлснээр Токио хотын захирагчийн сонгуулийг товыг ирэх сарын 14-ний өдөр зарлаж, 31-ний өдөр нь санал хураалтыг зохион байгуулахаар төлөвлөж байгаа гэнэ. Гэхдээ өдрийг албан ёсоор товлоогүй байгаа бөгөөд өнөөдөр зөвлөл хуралдаж, хотын сонгуулийн хороог байгуулж санал хураалт явуулах өдрийг хэлэлцэх юм байна. Хуульд зааснаар хотын захирагч хугацаанаасаа өмнө огцорсон тохиолдолд тухайн өдрөөс хойш тав хоногийн дотор сонгуулийн товыг зарлах ёстой байдаг аж. Мөн 50 хоногийн дотор сонгуулийн санал хураалтыг явуулах талаар заасан байдаг юм байна.

> ...Ёичи Масузоэ 2014 оны хоёрдугаар сард Токио хотын захирагч асан Иносэ Наокиг авлигын хэргээр суудлаасаа огцорсны дараах сонгуульд 2.11 сая хүний санал авч сонгогдсон юм...

Ёичи Масузоэ 2014 оны хоёрдугаар сард Токио хотын захирагч асан Иносэ Наокиг авлигын хэргээр суудлаасаа огцорсны дараах сонгуульд 2.11 сая хүний санал авч сонгогдсон юм. Гэвч хилийн чанадад дахь аялалд хэт их мөнгө үрж байна гэх шүүмжлэлд өнгөрөгч гуравдугаар сараас хойш тасралтгүй өртөх болсон байдаг. Ямартай ч, албан тушаалаасаа огцрох өргөдлөө өгөхөөсөө өмнө тэрбээр "Би хотын иргэдийн итгэлийг алдлаа. Би хэзээ ч хууль зөрчиж байгаагүй" хэмээн мэдэгдэж, олны шүүмжлэлийг эргүүлэхийг оролдсон ч бүтэлгүйтсэн бололтой. Тэрбээр ийнхүү огцорсноор "Токио-2020" зуны олимпийн бэлтгэл ажилд саад учруулж болзошгүй гэж зарим эх сурвалж онцолж байна.

## Шанхайд "Дисней ресорт" нээгдлээ

БНХАУ-ын Шанхай хотноо өчигдөр "Шанхай дисней ресорт"-ын нээлт болжээ. Америк соёлын импорт ч гэж нэрлэж болохуйц диснейн цогцолборыг Коммунист намын тогтолцоот Хятадын дундаж давхаргынханд зориулан нээсэн байна. Өчигдөр тухайн бүс нутагт бороо орж байсан ч, нээлтээ хийгээд ердөө 30 минутын дараа гэхэд хэдэн мянган хүн цугларсан байсан талаар албаны эх сурвалж мэдээлсэн байна. Түүнчлэн яаран сандран гүйж ирэх хүмүүс ч олон байжээ. Уолт Дисней компани болон БНХАУ-ын консорциум хамтран 2011 оноос эхлэн Шанхайн Пудон дүүрэгт цогцолборыг барьжээ. Энэхүү цогцолбор нь дэлхийн зургаан оронд буй диснейн томоохон паркуудын нэг болж байгаа юм. Хонконгод 2005 онд "Диснейлэнд"-ыг нээсэн байдаг ч, Хятадад анх удаагаа нээж буй нь энэ юм. Хятадын нутаг дахь тоглоом, зочид буудал болон арилжааны байгууламжуудыг багтаасан анхны том байгууламж болж буй диснейн цогцолбор нээгдсэнээр эдийн засаг, аялал жуулчлалын салбар нь хөгжинө гэж тус улсын албаныхан ихээхэн найдлага тавьж буй ажээ. Дашрамд дурьдахад, АНУ-ын Флорида мужийн диснейн ресортод саяхан харамсалтай хэрэг гарсан. Зочид буудлын өмнөх хиймэл нууранд матар хүн рүү дайрч, хоёр бага насны хүүхэд ор сураггүй алга болсон юм. Харин өчигдөр хүүхдүүдийн цогцос олджээ.




## КИМ КАРДАШИАН "GQ" СЭТГҮҮЛД ХУЦГЭЛЭВ

ДЭЛГЭРЭНГҮЙГ MMINFO.MN САЙТААС ҮЗЭЭРЭЙ

## Сүйрсэн онгоцны хэсэг олджээ

Газар дундын тэнгист өнгөрсөн сард сүйрсэн Египетийн онгоцны зорчигчдын хэсгийн бүхээгний зарим хэсэг олджээ. Тус онгоцны сүйрлийн шалтгааныг тогтоох комиссын мэдээлснээр онгоцны хэлтэрхийг эрэн хайх багт харьяалагдаж буй Францын шумбагч усан онгоц хэд хэдэн хэлтэрхийг олсон аж. Францын нийслэл Парис хотоос Египетийн Кайро хотыг чиглэн ниссэн Эйрбус А320 нисэх онгоц тавдугаар сарын 19-ний өдөр 66 зорчигч тээвэрлэж яваад ор сураггүй болсон юм. Улмаар энэ сарын эхээр Газар дундын тэнгист онгоцны хар хайрцганы дохио илэрч, далайн 3000 метрийн гүнд онгоцыг хайх ажиллагаа эхэлсэн. Хар хайрцаг гэж нэрлэгдэх нислэгийн бичлэг болон онгоцны бүхээгийн дуу хураагуурын баттерэй нь хангалттай цэнэгтэй тохиолдолд 4-5 долоо хоногийн хугацаанд дохио дамжуулдаг байна. Гэвч эрлийн багийнхан энэ сарын сүүлч болохоос өмнө хар хайрцгийг олох шаардлагатайг анхааруулж байгаа юм. Онгоцны ослын шалтгаан одоогоор тодорхойгүй байгаа. Гэхдээ террорист халдлага байж магадгүй хэмээн албаныхан таамаглаж байгаа билээ.

## Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ хэвээр үлдээлээ

АНУ-ын Холбооны нөөцийн банк дөрвөн удаа дараалан хуралдсаны эцэст бодлогын хүүгээ өөрчлөхгүй байх шийдвэр гаргажээ. Тодруулбал, тус банкны мөнгөний бодлогын зөвлөл хоёр өдөр хуралдсаны эцэст бодлогын хүүг 0.25-0.5 хувийн төвшинд хэвээр хадгалахаар шийдсэн байна. Холбооны нөөцийн банк өсөн жил зургаан сарын хугацаанд нэмэгдүүлээгүй бодлогын хүүгээ өнгөрсөн оны арванхоёрдугаар сард анх удаагаа нэмсэн байдаг билээ. Харин энэ удаа хэвээр үлдээх шийдвэр гаргасан тухайд "Эдийн засагт ахиц гарсан хэдий боловч тавдугаар сард хөдөлмөрийн зах зээлийн байдал тодийлон сайжирсангүй" гэх тайлбарыг хийсэн байна. Мөн Европын Холбооноос гарах эсэхийг шийдэх Их Британийн бүх нийтийн санал асуулга нь санхүүгийн зах зээлд хэрхэн нөлөөлөхийг Холбооны нөөцийн банк нухацтай ажиглах болно гэдгээ мэдэгдсэн байна. Их Британид Европын холбоонд үлдэх эсэх асуудлаарх бүх нийтийн санал асуулга энэ сарын 23-ны өдөр болох билээ. Британичууд ямар шийдвэр гаргахаас хамаарч тус улс болон Европын холбоонд том өөрчлөлт орж мэдэхээр байгаа юм.

# ШУУРХАЙ МЭДЭЭ

## ХУВЬЦААГАА ХӨДӨЛГӨӨНД ОРУУЛАХЫГ ХҮСВЭЛ ДАНС НЭЭЛГЭХ ШААРДЛАГАТАЙ

Н.БАТЗАЯА

*Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын Санхүү бүртгэл, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Б.Бадрахаас 1072 хувьцаатай холбоотой зарим зүйлийг тодруулллаа.*

**-Засгийн газраас 1072 хувьцааны 30 хувийг 300 мянган төгрөгөөр худалдаж авах шийдвэр гаргасан. Хувьцаа худалдаж авахтай холбоотой хэд хэдэн тодорхой бус асуудлууд байна. Иргэд хувьцаагаа зарахын тулд заавал брокер диллерийн компанид данс нээлгэсэн байх шаардлагатай юу?**

-Засгийн газраас иргэдийн 322 ширхэг хувьцааг арилжааны банкуудаар дамжуулан худалдан авах шийдвэр гаргасан. Иргэд брокер диллерийн компанид заавал данс нээлгэсэн байх шаардлагагүй. Бүх хувьцаа эзэмшигч байгаа хүмүүсээс хүсэлтийг нь авч, худалдан авч байгаа. Тиймээс иргэд хувьцаагаа зарах хүсэлтээ гаргахад л болно.

**-Брокер, диллерийн компанид данс нээлгэсэн 700 мянган хүн байна гэсэн. Тэр хүмүүс яах вэ. Ямар ч ашиггүй данс нээлгэсэн гэсэн үг үү?**

-Брокер, диллерийн компанид данс нээлгэсэн хүмүүсийн үлдсэн 70 хувийн хувьцааг үе шаттайгаар Монголын хөрөнгийн биржээр дамжуулан худалдаж авах юм. Гэхдээ яг хэзээ худалдаж авах нь Засгийн газраас гаргасан тогтоолд ороогүй. Хэрвээ худалдаж авахаар болбол брокер диллерийн компанид нээлгэсэн данс хэрэг болно. Хувьцаа худалдаж авах ажлыг нь Сангийн яам хариуцаж байгаа. Ер нь хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулж авах ёстой юм билээ. Би халамжийн ажилтан учраас тэр талаар сайн мэдэхгүй. Гэхдээ Засгийн газраас арилжааны банкуудаар дамжуулж иргэдийн хувьцааг худалдаж авах шийдвэр гаргасан. Зөвхөн иргэн өөрөө хүсвэл гэсэн заалттай. Нэгдүгээрт, хөрөнгийн бирж дээр иргэдийн хувьцаа гараагүй учраас 30 хувийн хувьцаа худалдаж авья гэдэг саналыг Засгийн газар гаргасан. Хоёрдугаарт, манай брокер диллерийн компаниудын чадамж нөхцөл байдал ямар байгаа билээ. Арилжааны банкуудаар авахад л ийм их ачаалал үүсч байхад брокер диллерийн компаниудаар дамжуулж авбал ямар байх нь ойлгомжтой. Тиймээс арилжааны банкуудаар гаргах шийдвэрийг Засгийн газраас гаргасан юм билээ. Манай агентлагийн хувьд Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Ингэхдээ арилжааны банкуудад гаргасан иргэдийн хүсэлтийг авч, баталгаажуулан Монголбанкаар дамжуулаад хувьцааны төлбөрийг иргэдийн дансанд шилжүүлэх юм.

**- Брокер, диллерийн компанид данс нээлгээгүй хүмүүс үлдсэн хувьцаагаа хөдөлгөөнд оруулахын тулд данс нээлгэх ёстой гэсэн үг үү?**

-Тийм. Үлдсэн 70 хувиа хөдөлгөөнд оруулахыг хүсвэл заавал брокер диллерийн компанид данс нээх шаардлагатай.

**-Арилжааны банкууд хувьцаа худалдаж авахдаа өөр өөр материал бүрдүүлж авч байна. Зарим нь иргэний үнэмлэхээ гурван хувь хувилсан байх ёстой гэж байхад зарим нь иргэний үнэмлэхний хуулбар, мөн маягт бөглөнө гэх юм. Энэ ямар учиртай юм бэ. Ер нь яаж авах нь зөв юм бэ?**

-Засгийн газрын тогтоолд иргэн хувьцаагаа хэрхэн худалдах талаар заасан. Иргэн хүсэлт бөглөх ёстой. Хүсэлт нь гурван ширхэг байна. Гурван ширхэг хүсэлтийн нэг нь банкинд, нэг нь тухайн иргэнд байх ёстой. Харин үлдсэн нэгийг нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв буюу хувьцааны хасалтыг хийх байгууллага авах юм. Тэгэхээр нэгдүгээрт, хүсэлт бөглөсөн байх хэрэгтэй. Хоёрдугаарт, иргэний үнэмлэхний хуулбарыг хүсэлтдээ хавсаргасан байх ёстой. Зарим банкууд хүсэлтийн маягт болон иргэний мэдээллийг программд шивж, хэвлэсний дараа иргэнээр гарын үсэг зуруулж байгаа байх. Хүсэлт дээр иргэн өөрөө заавал гарын үсэг зурсан байх ёстой.

**-Материал бүрдүүлж өгснөөс хойш долоо хоногийн дараа эхний удаагийн 100 мянган төгрөг орно гэсэн. Эхний удаад авах хүмүүсийн санхүү орж ирсэн үү?**

-Иргэдийн хүсэлтийг энэ сарын 13-наас эхэлж авсан. Тэгэхээр энэ сарын 20-нд хувьцааны эхний ээлжийн төлбөрөө авах юм. Төлбөрийг гурав хувааж өгнө. Засгийн газрын тогтоолд Сангийн яам 1.65 их наяд төгрөгийн бонд гаргана гэж заасан. Санхүүжилтын асуудлын тухайд Сангийн яам илүү дэлгэрэнгүй мэдээлэл өгөх байх.

**-Хувьцааны төлбөрийг яагаад бөөн өгөхгүй байгаа юм бэ. Гурав хуваах авахаар үр бүтээлтэй зүйлд зарцуулагдахгүй. Бөөнд нь өгөх хэрэгтэй гэж зарим хүмүүс ярьж байна?**

-Зах зээлд хэт их мөнгөний нийлүүлэлт үүсэхээс сэргийлж гурав хуваах өгч байгаа. Өөрөөр хэлбэл, бөөн өгвөл зах зээлд хэт их мөнгөний нийлүүлэлт үүссэнээс болж үнийн хөөрөгдөл болж, инфляци өсөх магадлалтай. Үүнийг дагаад өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өснө. Тиймээс гурав хуваах өгч байгаа. Бөөн өгөхгүй.

**-Хувьцаагаа зарсан иргэд эргээд Засгийн газраас хувьцаагаа худалдаж авах боломжтой юу?**

-Болно. Хоёр, гурван жилийн дараа хувьцаа үнэд орох үед хувьцаагаа худалдаж авч болно. Гэхдээ тухайн үеийн ханшаар биш одоо хувьцаа худалдаж авч байгаа үнэ буюу 934 төгрөгөөр авах боломжтой.

**-Одоогийн байдлаар хэчнээн хүн хувьцаагаа зарсан байна вэ?**

-Өнөөдрийн /өчигдөр/ 11:00 цагийн байдлаар 710 мянган хүн хувьцаагаа зарах хүсэлт гаргасан байна. Гэхдээ энэ тоо бол зургадугаар сарын 13-наас хойш өнөөдрийн 11:00 цаг хүртэл бүртгүүлсэн хүмүүсийн тоо.

**-Хүүхдийн хувьцааг яагаад зарж болохгүй байгаа юм бэ. Хүүхдийнхээ хувьцааг зарах сонирхолтой иргэд байна?**

-Хүүхдийн хувьцааг зарж болно. Гэхдээ тухайн хүүхэд 18 нас хүрсэн байх шаардлагатай. Нэг зүйлийг иргэд ойлгох хэрэгтэй. Энэ бол хүүхдийн мөнгө биш, халамжийн мөнгө биш. Засгийн газраас иргэнд тавьж байгаа "хувьцаагаа худалдах уу" гэсэн санал юм. Засгийн газрын тавьж байгаа нөхцөл нь тухайн иргэн 18 нас хүрсэн байх ёстой. Өөрөөр хэлбэл, эрхзүйн чадамжтай болсон байх шаардлагатай гэсэн үг. Хэн нэгнээр дамжуулж биш өөрийн хүсэлтээр хувьцаагаа зарах эсэхээ шийдэх эрхтэй байх юм. Ер нь Засгийн газар, иргэн хоорондын хувьцаа худалдахад хийж байгаа гэрээ гэдэг талаас нь ойлгох хэрэгтэй.

**-Хувьцааг хэдэн хүртэл худалдаж авах вэ. Хугацаа заасан уу?**

-Хувьцаа худалдах саналыг тэдний өдрөөр худалдаж авна гэсэн зүйл байхгүй. Цаашид үргэлжилсээр байна.

## Хатуу хог боловсруулах шинэ технологи нэвтрүүлнэ

Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч Т.Бат-Эрдэнэ, Улаанбаатар хотын Ерөнхий менежер Б.Бадрал нар "Азийн хотуудын нөөцийн цогц менежмент Хотын Nexus" төслийн дэмжлэгтэйгээр Герман улсад ажлын айлчлал хийж байна. Айлчлалын үеэр Германы Мюнхэн хотод хоёр жилд нэг удаа болдог IFAT 2016 байгаль орчны салбарын томоохон яармагт оролцож хатуу хог хаягдал боловсруулах, цэвэр бохир усны цэвэрлэгээний сүүлийн үеийн технологитой танилцжээ. Тухайлбал Германы Bergmann компанийн жижиг цэвэрлэх байгууламж, Bilfinger компанийн ариутгах татуургын вакум технологи, Ultrawaves компанийн бохирын лаг боловсруулах технологийн ажиллагаатай танилцан Монголд шинэ техник технологийг нэвтрүүлэх талаар ярилцаж хамтран ажиллахаар санал солилцжээ. Форумаас 2030 он хүртэлх "Тогтвортой хөгжлийн зорилтууд"-ыг хэрэгжүүлэхэд дэлхийн хотууд голлох үүрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрч, тэдгээрийн эрх мэдлийг дээшлүүлэх, иргэдийн тав тухтай амьдрах орчинг бүрдүүлэх, хотын хөгжлийг цогцоор нь хэрэгжүүлэх зэрэг "Берлины Зөвлөмжүүд"-ийг гаргасан байна.

PHOTO NEWS







*"Жуулчдыг гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх, жуулчидтай холбоотой гарсан гэмт хэрэг, зөрчлийг шуурхай шийдвэрлэх" зорилготой "Оюутан цагдаа" хөтөлбөрийн хүрээнд оюутнууд энэ сарын 15-нд эргүүлд гарч эхэллээ. Энэ жил 110 оюутантай гэрээ байгуулжээ. Оюутан цагдаа нар наймдугаар сар хүртэл эргүүлд гарна.*

## Ч.Өнөртүвшинг дахин шалгаж эхэлжээ

2015 оны арваннэгдүгээр сард Чингис Өнөртүвшин гэх фэйсбүүк хаягтай хэрэглэгч өсвөр насны охид руу "Зургаа авахуулах уу. Хамтарч ажиллая. Би чамайг фото модель болгож өгнө" гэх мэтээр санал тавьж, улмаар зураг авсны дараа нүцгэн зургийг чинь цахим хуудсаар цацна гэх мэтээр дарамталж, ёс бус үйлдэл хийхийг шаарддаг байсан тухай мэдээлэл цацагдсан билээ. Түүний хохирогч болсон гэх, мөн зураг авах санал авсан олон ч охид бусгүйчүүд энэ талаарх мэдээллийг ил болгож цагдаагийн байгууллагаас хэрэг үүсгэн шалгаж эхэлсэн. Гэвч тэд удалгүй Ч.Өнөртүвшин иймхэрэгт хамааралгүй хэмээн цагдаагийн байгууллага хэрэг үүсгэхээс татгалзаж байсан билээ. Ч.Өнөртүвшин гэгчийг шалгуулахаар өгсөн охид гомдлоо татсан учраас ийн хэргийг хэрэгсэхгүй болгосон гэдгийг цагдаагийн байгууллагын албан тушаалтан онцолж байлаа. Тэгвэл эх сурвалжийн өгсөн мэдээллээр Ч.Өнөртүвшин гэгчийн гэмт үйлдлийг цагдаагийн байгууллага баримтжуулж, улмаар хэрэг үүсгэн шалгаж эхэлжээ. Хэргийг Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтэс шалгаж буй юм байна. Дашрамд дурьдахад, цагдаагийн байгууллага энэ сард олон нийтийн цахим сүлжээнд садар самуун агууламжтай контент байрлуулан, бусдад таран сурталчилж буй хэрэглэгч, хаалттай нууц бүлгэм, хуудас мөн бусдыг биеэ үнэлэхэд зуучилсан, биеэ үнэлэхэд татан оролцуулж байж болзошгүй 100 орчим цахим хуудас болон бүлгэмийг олж илрүүлэн, шалгаж эхэлжээ.

## Арьс шир, ангийн үслэг боловсруулах 28 үйлдвэрийн үйл ажиллагааг зогсоолоо

Нийслэлийн сая 500 мянга гаруй иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрахад орчин, хөрс, агаарын, усны асуудал хамгийн чухал сэдэв байсаар ирсэн. Тиймээс Шадар сайд Ц.Оюунбаатарын тушаалаар Батласан дирдамжийн дагуу МХЕГ-аас "Ус сувгийн удирдах газар", "Харгиа" урьдчилан цэвэрлэх байгууламж, зарим арьс шир боловсруулах үйлдвэрүүдэд сэаян хяналт шалгалт хийсэн юм байна. МХЕГ-ын дэд дарга П.Ангарагаар ахлуулсан шалгалтын хэсэг Хан-Уул дүүргийн 02 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг арьс шир, ангийн үслэг боловсруулах үйлдвэрүүдэд хяналт шалгалт хийж, байгаль орчны үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй зэрэг ноцтой зөрчлүүдийг илрүүлжээ. Иймд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.7 дахь заалтыг үндэслэн арьс шир, ангийн үслэг боловсруулах "Мон–Ит-Булигаар", "Монгол Шевро", "Белон", "Шандаст-Аргамаг", "МЛТЖ", "Ярмаг-1", "Элит фур", "Лидер-Арена", "Их эргэлт", "Ерөөлт интернейшл", "Мон-Ирээдүй"," зэрэг үйлдвэрийн үйл ажиллагааг түр хаасан байна. Мөн "Гурван –Эрдэнэ", "Их-Асар","Сүүдэртийн хөндий", "Мастер додо"", Эрдэнэ чандмань", "Ялман", "Батдүмбээ","Сутайн дэвшил", "Хатан төгөл", "Үе импекс", "Арилдий" зэрэг ХХК 28 үйлдвэрийг гаргасан зөрчлөө арилгуулах хүртэл үйл ажиллагааг нь зогсоох тухай Улсын ахлах байцаагч акт тавьжээ.

## "UB DANCE FESTIVAL-2016 тэмцээн ням гарагт эхэлнэ

"UB DANCE FESTIVAL-2016" олон улсын бүжгийн тэмцээн энэ сарын 19 буюу ням гарагт Чингисийн талбайд болох аж. Хоёр дахь жилдээ болж буй уг тэмцээнийг "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Соёл урлагийн газраас "Extreme Crew Studio"-тай хамтран зохион байгуулж байгаа ажээ. Энэ жилийн фестивальд Япон, БНСУ, БНХАУ-ын ӨМӨЗО-ны бүжгийн хамтлагууд оролцох юм. Фестивалийн үеэр хамтлаг бүжгийн улсын аварга, 1vs1 бүх төрлийн гудамжны бүжгийн аварга, Graffiti, гудамжны урлагийн аварга, Parkour & Freerunning, Extreme sport-н аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулахаар болжээ. Мөн олон улсын бүжигчдийн болон сошиал бүжгийн үзүүлбэр, сургалтууд болох аж. Тэмцээн өглөөний 11.00 цагт эхэлнэ.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## Зам тээврийн осолд дөрвөн хүүхэд өртжээ

Замын цагдаагийн ерөнхий газарт өнгөрсөн лхагва гарагт нийт 306 дуудлага ирснээс 232 нь ослын дуудлага байсан байна. Үүнээс хүүхэд зам тээврийн осолд өртсөн дөрвөн дуудлага бүртгэгджээ. Тодруулбал, БГД-ийн нутаг Энхтайвны өргөн чөлөө, Төмөр замын урд замд "Т Prius" маркийн авто машины жолооч Б нь явган зорчигч таван настай С-г мөргөж гэмтээсэн байна. Мөн ХУД-ийн нутаг Чингисийн өргөн чөлөө, Ярмагийн гүүрний урд замд "Benz E270" маркийн машины жолооч унадаг дугуйтай хүүхдийг мөргөж, гэмтээсэн аж. Тиймээс эцэг эхчүүд бага насны хүүхдээ хараа хяналтгүй замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх, асран хамгаалуулагчгүй эрсдэлтэй газар тоглуулахгүй байхыг Замын цагдаагийн газраас анхааруулллаа.

# ЗАВСАРЛАГА

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ЗУРАГ

## Газар хөдлөлтийн дараа



Б.ДАВАА

Австралийн гэрэл зурагчин Даниэл Берехулак энэ зургийг өнгөрсөн оны дөрөвдүгээр сарын 29-ний өдөр авчээ. Энэ өдрийг сонсмогц уншигч таны санаанд нэгэн аймшигт байгалийн гамшигт үзэгдэл тод буух нь гарцаагүй. Тэр бол Балбын газар хөдлөлт.

Яг энэ өдрөөс дөрөв хоногийн өмнө Балбын нийслэл Катманду хотноо 7.8 магнитудын хүчтэй газар хөдөлж, газар хөдлөлтийн дараах чичиргээн хэд хэдэн удаа мэдрэгдсэн байдаг. Хүн төрөлхтөний түүхэнд хамгийн их хохирол дагуулсан байгалийн гамшигт үзэгдлийн тоог нэгээр нэмсэн энэхүү газар хөдлөлтийн улмаас 8000 гаруй хүн нас барж, 21 мянга гаруй хүн гэмтэж бэртсэнээс гадна үй олон байшин барилга нурж сүйджээ. Тэр тусмаа орон нутгийн уулын бүсэд орших тосгодууд хамгийн их хохирол амсч байв. Дэлхийн өнцөг булан бүрээс хүмүүнлэгийн ажилтнууд туслахаар ирж байсан ч, алслагдсан тосгодын иргэдэд тусламж хүргэх ажил нэлээд хүндрэлтэй байсан гэдэг. Ямартай ч, энэ газар хөдлөлтөөр Балбын 2.8 сая хүн орон гэргүй болон үлджээ. Тэдгээр орон гэр гэргүй болсон хүмүүсийн нэгхэн төлөөлөл нь зураг дээрх хосууд юм. Балбын Бхагтапурт газар хөдлөлтийн улмаас нурсан байшингийнхаа цонхоор эхнэр рүүгээ хувин дамжуулж буй нэгэн эр гэрэл зургийн торгон хальснаа ийн буусан байна. Энэ зураг дэлхийн хэвлэлийн шилдэг гэрэл зураг шалгаруулах “World press photo-2016” наадмын Ерөнхий мэдээний төрөлд гутгаар байр эзэлсэн юм.

Улаанбаатарт:

Маргааш

Өдөр +28
Шөнө +14

Нөгөөдөр

Өдөр +22
Шөнө +9

### Өдрийн зурхай

**Аргын тооллын:**
*2016 оны 6-р сарын 16, Баасан гараг*

**Билгийн тооллын:**
*Шинийн 12. Нэг цагаан мэнгэтэй Цагаан морь өдөр.*

**Наран ургах/шингэх:**
*05:59 / 21:50*

**Үс засуулбал:**
*Өвчин эмгэг ирнэ*



Тухайн өдөр нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэмтнийг шийтгэх, угаал үйлдэх, тангараг тавих, гэр, байшингийн суурь тавихад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар явах одогсод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.




